Монгол түмэн минь сар шинэдээ сайхан шинэлээрэй

МОНГОЛ УЛСЫН ЗГМ ШИЛДЭГ СОНИН

ЗАСГИЙН ГАЗРЫН МЭДЭЭ

2018.02.14, ЛХАГВА ~ №036 (835) ~ СОЁЛТ ХҮНИЙ ӨГЛӨӨ СОНИН УНШИХААС ЭХЭЛДЭГ ~ ҮНЭ: 1000₮

Дөрөвдүгээр төрөхийг барих хөрөнгийг шийдээрэй

2018 оны хөрөнгө оруулалтын жагсаалтад дөрөвдүгээр төрөх ороогүй. > 4

Баялгийн сангийн менежментийг гадны багаар гүйцэтгүүлнэ

“Эрдэнэс Тавантолгой”-н хувьцааг есдүгээр сарын 30 гэхэд арилжихаар төлөвлөв. > 12

FT FINANCIAL TIMES

- **Авлигын эсрэг хууль яллагдагчийг ямар ч хамгаалалтгүй болгоно**
- **АНУ, Умардтай хэлэлцээ өрнүүлэхэд бэлэн**

ZGM DAILY

Marketintel: Plugging budget deficit with ADB financing is inefficient

Solutions to budget deficit may draw criticism. > 7

ОНЦЛОХ

УЛС ТӨР

Сангийн яамны ТНБД-аар С.Наранцогтыг томилуулах дүгнэлтийг ТАЗ гаргалаа.

Элчин Сайд Ц.Жамбалдорж Албани улсын Ерөнхийлөгчид итгэмжлэх жуух бичгээ барив.

Дэгийн хуулиар гишүүдийг бэлэг тараахыг хориглох хэрэгтэй байна.

УИХ-ын Өргөдлийн байнгын хороо 6703 иргэний өргөдлийг шийдвэрлүүлжээ.

ЭДИЙН ЗАСАГ

Ердийн хэрэглээний 38 хоногийн газрын тосны бүтээгдэхүүний нөөцтэй байна.

Үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбооны үйл ажиллагааг хангалтгүй гэв.

Дэлхийд аялал жуулчлалын салбар улам хүчээ авах төлөвтэй байна.

“S&P” агентлаг Rio Tinto компанийн зээлжих зэрэглэлийг "A-"-аас "A" болгон сайжруулав.

Хөрөнгийн биржийн MSE ALL индекс 1186.26 нэгж болж, 1.94 хувиар өсөв.



НИЙГЭМ

Энэ сарын 16-19-ний хүртэл дугаарын хязгаарлалт үйлчлэхгүй.

Сар шинийн өдрүүдэд 760 алба хаагч замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангана.

Цахим орчинд худалдан авалт хийхдээ тухайн улсын хуулийг судлахыг зөвлөж байна .

Монгол данжуурын гэрэлт хөшөө ЮНЕСКО-гийн дэлхийн соёлын өвд бүртгэгджээ.

ДЭЛХИЙ

АНУ-ын шинэ төсөвт ОХУ-ыг тогтоон барих 6.3 тэрбум ам.доллар төсөвлөгджээ.

Хулгайлагдсан иргэдээ буцааж өгөхийг Шинзо Абэ Умард Солонгосоос шаардав.

Венесуэл ОПЕК-ийн тохиролцоог дахин таван жил сунгах саналтай байна.

Манчестерийн их сургууль үүдэл эсээр хүний ходоод ургуулж туршлаа.

ЦАГ АГААР

УЛААНБААТАР

2018.02.14

-12° | -23°

БАГАВТАР ҮҮЛТЭЙ

ЦАГ АГААРЫН ДЭЛГЭРЭНГҮЙ МЭДЭЭЛЛИЙГ 8 ДУГААР НҮҮРЭЭС УНШИНА УУ.

8 658000 029112 00835

Бүх эрх хуулиар хамгаалагдана ©

Нүүдэлчдийн заншлын өв, зочломтгой зангийн илрэл болсон ахуйн эд хэрэглэл шинэ цагийн хийц, уураар өнгө, чанар нэмж, нийтийн хэрэглээнд дэлгэрээд байна. Дэлхийд Монголын нэрийг гаргах үнэ цэнэтэй брэнд бидний зан заншил, өв соёлд оршин байна. ▶6

С.Батсайхан / ЗГМ©

ЗГМ: СУРВАЛЖИЛГА

Утаанаас илүү хордуулагч өмхий лагаа яах вэ

Б.Баярмаа
@bayarmaaZGM

Улаанбаатарчууд утаанаас салж, цээж дүүрэн амьсгалах хаврын урин цаг айсуй. Гэвч нийслэлийн зарим иргэдэд ийм боломж алга. Толгойт буюу хуучнаар Орбитын тойрог орчимд амьдардаг иргэд түүхий нүүрсний хорт утаанаас арайхийн салж буй ч Төв цэвэрлэх байгууламжийн өмхий лагийн үнэртэй золгож байна. Таван шараас эхлээд л толгой эргэм лагийн үнэр хамар цоргиулна. Төв цэвэрлэх байгууламжийн ойролцоох Хан-Уул, Сонгинохайрхан дүүргийн зарим хэсэгт автомашины цонхоо хааж, ам, хамраа дараад ч өмхий үнэр нэвт ханхалдаг энэ дүр зураг олон жил үргэлжилж буй.

Биднийг Толгойт бүсэд ирэхэд утаа багатай, салхи тогтуун, хаврын зөөлөн салхи сэвэлзэж байв. Гэвч төд удалгүй өнөөх үнэр энд салхиар туугдан ирж, амьсгалах аргагүй бохир ханхалж эхэллээ. Бохир агаараар, төв цэвэрлэх байгууламжийн 50 гаруй жил дагтаршсан лагийн үнэр гэж бодоход л дотор муухайрна.

▶3

ЗГМ: ЗОЧИН

Г.Мөнх-Очир: Нислэгийн бүх дүрэм журам цусаар бичигдсэн байдаг юм

Г.Баярсайхан
@bayarsaikhanZGM

Монгол Улсын гавьяат нисгэгч Готовын Мөнх-Очирыг сонинныхоо хүндэт зочноор урьж, ярилцлаа. Хөдөөгийн эгэл жирийн малчны хүү энэ өндөрлөгт хэрхэн хүрсэн түүхээ сонирхолтой хүүрнэсэн юм.

-Та хэсэг хугацаанд Өмнөд Америкт нислэг үйлдэж байгаад иржээ. Энэ нислэгийн талаар ярилцлагаа эхлэх үү?

-Манай МИАТ компани Гайти улсын “Санрайз” авиакомпанитай нойтон түрээсийн гэрээ байгуулсан юм. Нисгэгч, үйлчлэгч, техникийн ажилтан нийлсэн 36 хүний бүрэлдэхүүнтэй баг хоёр сарын турш Гайти, Чили улсын хооронд нислэг үйлдэж байгаад ирлээ. Гэхдээ би сүүлд нөхөн хангалтаар очсон юм. Чили уул уурхай өндөр хөгжсөн, том уурхайнуудтай улс юм билээ. Гайтигаас Чили рүү хар ажилчид их явна.

▶5

МЭНДЧИЛГЭЭ

Өвөг дээдсээс өвлүүлж үлдээсэн уудам сайхан нутгийнхаа өнцөг булан бүрт суугаа эх орон нэгт монголчууд аа, өргөн эх дэлхийн дөрвөн зүг найман зовхист амьдран суугаа элэг нэгт монгол ахан дүүс ээ.

Та бүхэндээ XVII жарны “Тийн унжлагат” хэмээх шороон нохой жилийн сар шинийн мэндийг өргөн дэвшүүлье.Улиран одож буй тахиа жилд төрийн тулгуур, улсын үндэс болсон айл өрхүүд маань 70 гаруй мянган үр хүүхдээр ам бүлээ нэмж, монголчууд бид 3 сая 200 мянгуулаа боллоо. “Хүн нэмбэл хүнс нэмнэ” гэж бэлгэшээдгээр буянт мал сүрэг өсөж 66 саяд хүрлээ.

Тогтоон барьсан эдийн засгаа томруулан өсгөж, айл өрх бүрийн авдар, иргэн бүрийн ирээдүйд хүртээх нь Монгол Улсын Засгийн газрын гол бодлого байх болно. Монголчууд бид эдийн засгаа 4 хувиар өсгөж чадлаа. Гадаад валютын нөөц нэг жилийн дотор 2,5 дахин нэмэгдэж 3,2 тэрбум доллар боллоо. Экспорт анх удаа 6 тэрбум долларт хүрч өслөө. Гадаадын шууд хөрөнгө оруулалт 1.1 тэрбум долларт хүрлээ. Чингис бондын 500 сая долларын төлбөрийг Засгийн газар цаг хугацаанд нь төллөө. Ингэснээр олон улсын хөрөнгө оруулагчдын итгэлийг сэргээж манай улсын зээлжих зэрэглэлийг дэлхийн голлох үнэлгээний агентлагууд нэг шат ахиулан, тогтвортой улс гэсэн ангилалд орлоо. Төсвийн сахилга батыг сайжруулснаар төсвийн алдагдлыг өмнөх жилтэй харьцуулахад 2 дахин бууруулж, ДНБ-ий 9 хувьд хүргэлээ. Төсвийн орлого 580 тэрбум төгрөгөөр давж биеллээ. Энэ бүгд монголчууд бидний хувьд тахиа жилд гаргасан чамлахааргүй амжилт юм.

Айлчлан ирж буй “Тийн унжлагат” хэмээх шороон нохой жилд Монгол Улсын Засгийн газраас зорилт болгосон улсаа хүнсний орон болгох, эрчим хүчний хэрэгцээгээ бүрэн хангах, газрын тосыг дотооддоо боловсруулах, агаар орчны бохирдлыг бууруулах, хөдөө аж ахуй, газар тариалан, хөнгөн үйлдвэрлэл зэрэг гол ажлуудаа эрчимжүүлэх болно.

Түүнчлэн ард түмнийхээ бодит орлогыг өсгөх, ажлын байрыг нэмэгдүүлэх, сургууль цэцэрлэгээр хангах, тэтгэвэр тэтгэмжийг нэмэгдүүлэх, автозам, төв цэвэрлэх байгууламжийг шинэчлэх зэрэг дэд бүтэц, бүтээн байгуулалтын томоохон ажлуудыг хэрэгжүүлж, газрын доорх баялгийн иргэдэд оногдох өгөөжийг нэмэгдүүлэх их бүтээлийн жил байх болно. Монгол хүн бүрийн зүрх сэтгэлд мөнхөд оршдог, эв нэгдэл, их ухаан, эрч хүч хайрладаг аугаа үнэт зүйл бол тусгаар Монгол эх орон минь юм. Энэ сайхан эх орондоо монгол хүн бүр эрүүл энх, аз жаргалтай, элбэг хангалуун амьдрах нөхцөл, боломжийг бүрдүүлэхийн төлөө Монгол Улсын Засгийн газар, Монгол Ардын Нам хичээн зүтгэх болно.

Ирж буй XVII жарны “Тийн унжлагат” хэмээх шороон нохой жилдээ иргэн бүр эрүүл саруул, энх амгалан, алсдаа уужуу, холдоо зорилготой, хоймортоо сүлдтэй, хотондоо ашиг шимтэй байх болтугай. Айл өрх бүрийн амьдрал ахуй өөдлөн дэвжиж, Төр улсаараа элбэг дэлбэг, Түмэн олноороо тэнүүн жаргалтай амьдрахын ерөөл өргөн дэвшүүлье.

Сар шинэдээ сайхан шинэлээрэй

МОНГОД УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД
У.ХҮРЭЛСҮХ

АЛТ	ЗЭС	ХУРАЛДАЙ БОНД	10-ЧИНГИС БОНД	ГЭРЭГЭ БОНД	АМ.ДОЛЛАР	ЮАНЬ	РУБЛЬ
1329	6831	114.75	99.440	101.15	2400.13	378.17	41.51
0.49%	1.13%	0.02%	0.04%	0.05%			

Улс төр

ТОВЧХОН

» ТОО

50

Жил. Олимпийн наадмаас Монгол Улс анх медаль хүртсэний 50 жилийн ойг тохиолдуулан УИХ-ын дарга М.Энхболд олимпийн дэвжээнээс медаль хүртсэн тамирчидтай уулзлаа. Уулзалтын үеэр тамирчид ЗГ-ын тогтоолоор олгож буй цалин, урамшууллыг УИХ-ын хууль, тогтоомжийн хэмжээнд баталгаажуулж өгөхийг хүссэн байна.

» ХАРИЛЦАА

Монгол Улсаас Бүгд найрамдах албани улсад суух Элчин Сайд Ц.Жамбалдорж тус улсын Ерөнхийлөгч Илир Мета Танд итгэмжлэх жуух бичгээ барьжээ. Албани нь Монгол Улстай дипломат харилцаа тогтоосон Европын анхны орон юм.

» ТӨСӨЛ

Засгийн газраас дайчилгааны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл өргөн барив. Уг төслийг УИХ-ын хаврын чуулганаар хэлэлцэхээр болжээ.

ТОДРУУЛГА & ЗАЛРУУЛГА

Уншигч та манай сонины мэдээ, нийтлэл, сурвалжилгатай холбоотой тодруулж, залруулах шаардлагатай санал, хүсэлт байвал
› **INFO@ZASAG.CO**

Утас: 99903584 хаягаар бидэнтэй холбогдоно уу.

ТОМИЛГОО

Сонгон шалгаруулалтад үүрэг гүйцэтгэгчид ялжээ

Төрийн албаны зөвлөл дүгнэлтээ Засгийн газарт хүргүүллээ

Б.Энхжаргал
@enkhjrglZGM

Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулсан зарим албан тушаалын сонгон шалгаруулалтын дүн гарчээ.

Тухайлбал, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Ашигт малтмал, газрын тосны газрын дарга, нийслэлийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргын сонгон шалгаруулалтын дүн гарсан байна.

С.Наранцогт, Х.Хэрлэн нарыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэнэ

Сангийн яамны Төрийн нарийн бичгийн даргаар С.Наранцогтыг, Ашигт малтмал, газрын тосны газрын даргаар Х.Хэрлэнг, нийслэлийн ИТХ-ын нарийн бичгийн даргаар Б.Батбямбыг тус тус томилуулахаар дүгнэлт гарган, нэр дэвшүүлжээ.

Тэгвэл Төрийн албаны зөвлөлөөс гаргасан дээрх дүгнэлтийг үндэслэн Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга болон Ашигт малтмал, газрын тосны газрын даргыг томилох асуудлыг Засгийн газар хэлэлцэж, эцэслэн шийдэх юм.

Дашрамд дуулгахад оны өмнө Засгийн газрын шийдвэрээр С.Наранцогт Сангийн яамны Төрийн нарийн бичгийн даргын үүрэг гүйцэтгэгчээр, Х.Хэрлэнг Ашигт малтмал, газрын тосны газрын даргын үүрэг гүйцэтгэгчээр томилсон юм.

С.Наранцогтын хувьд Төрийн банкны ТУЗ-ийн гишүүн бөгөөд ТУЗ-ийн дэргэдэх Хүний нөөц, урамшууллын асуудал эрхэлсэн хорооны даргаар ажиллаж байжээ. Тэрбээр Шинжлэх ухаан, технологи мэдээллийн төвд ахлах инженер, Сангийн яам, БСШУЯ, ХНХЯ-нд газрын дарга зэрэг албыг хашиж байсан аж. Харин Х.Хэрлэнгийн хувьд Ашигт малтмал, газрын тосны газрын Кадастрын хэлтсийн дарга, "Монгол шуудан" компанийн ТУЗ-ийн дарга, Монголын төмөр зам ТӨХК-ийн дэд дарга, "Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ХК-ийн ТУЗ-ийн дарга, Монгол, Болгарын хамтарсан "Монголболгаргео" ХХК-ийн ТУЗ-ийн дарга зэрэг албыг хашиж байжээ. [ЗГМ]

БАЙНГЫН ХОРОО

М.Оюунчимэг: Парламентын гишүүд бэлэг өгөхийг хориглодог хууль хэрэгтэй байна

БНСУ-ын хуульд гишүүд нь 5000 воноос дээш үнэтэй эд материал тараахыг хориглодог шиг хуультай болох хэрэгтэй.

Б.Ганбаяр / ЗГМ©

Б.Сэлэнгэ
ЗГМ

Ээлжит чуулганы хугацаанд УИХ-д нийт 13500 гаруй иргэнээс өргөдөл, гомдол иржээ. Тэдгээрийн 63 хувь нь Улаанбаатар хотын иргэд байгаа бол үлдсэн нь хөдөө орон нутгаас ирүүлсэн аж. Иргэдийн өргөдөл, гомдлын багагүй хэсэг нь агаарын бохирдолтой холбоотой байжээ.

Агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр өнгөрсөн хугацаанд ойролцоогоор 200 орчим тэрбум төгрөг зарцуулсан байна. Гэвч бодитой үр дүн гарахгүй байсаар өнөөдрийн хүрсэн. Тиймээс намрын чуулганы хугацаанд Өргөдлийн байнгын хорооноос тодорхой ажлууд зохион байгуулж, гэр хорооллын дахин төлөвлөлт, Засгийн газарт тодорхой үүрэг чиглэл өгч ажилласан хэмээн тус Байнгын хорооны дарга М.Оюунчимэг хэлж байв. Үүний үр дүнд БНСУ-аас 0.2 хувийн хүүтэй урт хугацаатай авч буй зээлийг зөвхөн агаарын бохирдлыг бууруулах чиглэлд зарцуулахаар болсон гэв.

Тэрбээр мэдээллийн дараа сэтгүүлчдийн сонирхсон асуултад хариуллаа.

-Өргөдлийн байнгын хороонд УИХ-ын гишүүдийн ёс зүй, хариуцлагатай холбоотой өргөдөл, гомдол ирсэн үү. Түүнийг хэрхэн шийдвэрлэсэн бэ?

-УИХ-ын гишүүдтэй холбоотой өргөдөл, гомдол манай Байнгын хороонд ирээгүй. Харин ТЕГ-ын дарга асан Б.Хурцтай холбоотой асуудлаар иргэдээс гомдол, өргөдөл ирсэн. Уг өргөдөл, гомдлын дагуу нэр бүхий гишүүд иргэдтэй уулзаж, холбогдох хуулийн байгууллагад хандсан.

-Сар шинийн баяр болж буйтай холбогдуулан УИХ-ын гишүүд тойрогтоо ажиллаж, бэлэг тарааж эхэллээ. Тухайлбал, таныг гурил тарааж байна гэх мэдээлэл бий. Бэлэгний төсөв хаанаас гарсан бэ?

-УИХ-ын гишүүд бэлэг тарааж байна гэхээсээ илүүтэй тойргийнхоо өндөр настан буюу 70-аас дээш настай ахмадууддаа хүндэтгэл үзүүлсэн. Мэдээж, бусад УИХ-ын гишүүд тойргийнхоо ахмадуудад хүндэтгэл үзүүлж байхад манай тойргийн ахмадууд ч гэсэн "Бидэнд яагаад хүндэтгэл үзүүлэхгүй байна вэ" гэж бодно. Иймээс ч хүндэтгэл үзүүлсэн юм. Тэгэхдээ хийсэн ажлынхаа тайланг өгсөн болохоос биш элсэн чихэр, будаа, гурил тараахдаа гол нь биш шүү дээ. Тэгэхээр УИХ-ын тухай хууль, Дэгийн тухай хуульд өөрчлөлт оруулчихаж болно. Тухайлбал, БНСУ-ын хуульд парламентын гишүүд нь 5000 воноос дээш үнийн дүн бүхий эд материал иргэдэд тараахыг хориглоно гээд заачихсан байдаг. Үүн шиг хуульд тусгаад өгчихвөл бүх гишүүн гарын бэлэг өгдгөө болино. Ингэвэл надад ч амар. Улсын төсөвт тойрогт зарцуулсан мөнгө суух болоогүй. 2018 оны улсын төсөвт суусан. Энэ мөнгө нь гишүүдээр дамждаггүй. Тухайн салбарын яам, агентлаг, төрийн өмчийн хороогоор дамждаг, их хатуу болсон. Тиймээс ахмадуудын гарын бэлгийн төсвийг УИХ-ын гишүүд хувиасаа зохицуулдаг. [ЗГМ]

ИЛГЭЭЛТ

Монгол түмэндээ айлчлан ирж буй "Нөхөрсөг" хэмээх шар нохой жилдээ төрлөөрөө түвшин амгалан, элгээрээ энх амгалан байхын өлзийтэй ерөөлийг өргөн дэвшүүлье. Монголчууд бид хэзээнээс амны бэлгээс ашдын бэлгэ хэмээн бэлгэшээж, аливаа саар бүхнийг цайлгаж ирсэн сайхан уламжлалтай. Энэ сайхан эртний ёсыг үл эвдэн өтгөс буурлынхаа амрыг айлтгаж, өргөн түмнийхээ мэндийг мэдэхийн зэрэгцээ өвлийг өнтэй давж, хаврыг хавтай угтахын бэлгэдэл Сар шинийн баярын мэндийг та бүхэндээ хүргье.

"Алтан унжлагат" хэмээх тахиа жил Монгол түмний хувьд амаргүй олон сорилттой тулгарсан жил байлаа. Хоёр жилийн өмнө ард түмний итгэл найдварыг хүлээн сонгогдсон эрх баригчид хэдий 65-уулаа ч төрийн тогтвортой байдлаа хадгалж чадсангүй. Өвөр зуураа тэмцэлдсээр Засгийн газраа огцруулсан ч "Нуухыг нь авах гээд нүдийг нь сохлов" гэгч болжээ.

Төрийн ойлгомжгүй, тогтворгүй байдлын улмаас есөн төрлийн татвар нэмэгдэж, улс орон даяар бензин шатахууны хомсдол нүүрлэж, үүнийг дагаад өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүний үнэ өдрөөс өдөрт өсөх болов. Эдийн засгаа сүйрлийн хэмжээнд хүргэж, 40 хувьтай байсан өрийг таазыг 100 хувьд хүргэж, 2012-2016 онд авсан Чингис бондын 1.2 тэрбум доллараас даруй 1.3 тэрбумаар их буюу 2.5 тэрбум долларын зээл авсан ч ганц километр зам тавьсангүй, энэ гээд үзүүлчих бүтээн байгуулалт нэгийг ч хийсэнгүй.

2016 онд 1.3 хувийн өсөлттэй, мөн 1.3 хувийн инфляцтай улс орныг хүлээн авсан эрх баригчид дэлхийн зах зээл дээрх уул уурхайн бүтээгдэхүүний үнийн өсөлтийн нөлөөгөөр 5.3 хувь өссөн эдийн засгаа тогтоон барьж чадалгүй, сайд нарынхаа хэт үрэлгэн тансаглал, бодлогогүй, харалган шийдвэрийнхээ харгайгаар инфляцыг 8.6 хувь хүртэл хөөрөгдлөө. Ийнхүү эдийн засгийн өсөлтөө инфляцид идүүлж, Олон улсын валютын сан хэмээх гадны эрх ашгийг хамгаалсан байгууллагын амыг харж суудаг сул дорой төр нэгэнт бий болжээ.

Үүгээр зогсохгүй улс орныхоо эдийн засгийн гол хөдөлгөгч хүч болсон "Эрдэнэт" үйлдвэрийнхээ 51 хувийг гадны банкны барьцаанд тавьж, алдах дээрээ тулаад байна. Олгой хагаравч тогоон дотроо гэгчээр "Эрдэнэт" үйлдвэрийн 49 хувийн асуудал бол монголчуудын дотоод асуудал. Хэн ч эзэмшсэн Монголдоо үлдэх баялаг. Харин 51 хувийн асуудал бол Үндсэн хуулиар "Монголын нийт ард түмний мэдэлд байна" гэж заасан үлэмж их баялгийг үнэгүйдүүлж харь улсын өмчлөлд шилжүүлэх гэж буй увайгүй алхам юм.

Иймд Ардчилсан нам сөрөг хүчний хувиар Монголын нийт ард түмний өмнө хүлээсэн үүргээ биелүүлж, эрх баригчдын бодлогогүй, увайгүй алхмын эсрэг тууштай тэмцэл өрнүүлж,УИХ-ын дарга, Ерөнхий сайдад хугацаатай шаардлага хүргүүлж, "Бүх нийтийн эсэргүүцлийн жагсаал" зохион байгуулж, есөн төрлийн татварыг цуцлах, Утааны эсрэг бодитой, дорвитой шийдэл гаргах, Үндсэн хуульд өөрчлөлт оруулах замаар төрийн эрхийг хууль бусаар авах санаархлаа зогсоохыг шаардсан билээ. Эрх баригчид энэхүү шаардлагыг өнөөг хүртэл биелүүлээгүй төдийгүй иргэдийнхээ халаасыг сэгсэрсэн татварын бодлого үргэлжлүүлж, "Утаагүй" гэх утаат зуух тарааж, Үндсэн хуулийн бус аргаар Үндсэн хуульд гар хүрэхээр зэхэж байна.

Тиймээс Ардчилсан нам ард түмэнтэйгээ амь нэг байж, эрх баригчдын алдааг засч, зөв замыг зааж өгөхийн төлөө айлчлан ирж буй нохой жилдээ тууштай тэмцэх болно. Бид эрх баригчдаас шаардлагынхаа хариуг нэхэж дахин жагсах болно гэдгээ нийт ард түмэндээ мэдэгдэхийн ялдамд энэхүү тэмцэлд та бүхнийг нэгдэж төр түмэндээ үгээ хэлж, эсэргүүцлээ илэрхийлэхийг уриалж байна.

"Нөхөрсөг" хэмээх шар нохой жилдээ Монгол түмэн маань сар шинэдээ өргөн дэлгэр сайхан шинэлээрэй.

УИХ-ЫН ГИШҮҮН, АРДЧИЛСАН НАМЫН ДАРГА СОДНОМЗУНДУЙН ЭРДЭНЭ

ТАТАН БУУГДАВ

Хуулийн этгээдийн нэр: Хөрөнгө Оруулагч Үндэстэн хаалттай ХК
Татан буулгах үндэслэл, эрх бүхий байгууллагын шийдвэр: Хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрээр
Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар: 9010001135
Компанийн регистрийн дугаар: 6042104
Компанийн албан ёсны хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Ерөнхий сайд Амарын гудамж, Ард Санхүүгийн Нэгдлийн байр

Хөрөнгө Оруулагч Үндэстэн хаалттай ХК-ийн 2016 оны 8 дугаар сарын 25-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус, эчнээ санал хураалтаар Жинст Увс ХК-д нэгдэх замаар хоёр компанийг нэгтгэж, Хөрөнгө Оруулагч Үндэстэн хаалттай ХК-ийг татан буулгах шийдвэрийг баталсан болно.

ЗГМ: Сурвалжилга

Төв цэвэрлэх байгууламжийн шинэчлэлийн ажил хэзээ эхлэх нь тодорхойгүй

Төв цэвэрлэх байгууламжийн орчимд төрж, өссөн хүүхдүүд өмхий агаараар амьсгалсаар энэ байдалдаа аль хэдийнэ дасжээ.

Б.Ганбаяр / ЗГМ©

Утаанаас илүү хордуулагч өмхий лагаа яах вэ

◀1

Харин энэ хавийн оршин суугчид үүнд аль хэдийнэ дассан бололтой, ам хамраа дарсан, маск зүүсэн хүн огт харагдсангүй.

Сонгинохайрхан дүүргийн XXII хороо түр оршин суугчидтайгаа нийлээд 28 мянга орчим хүн амтай. Говь-Алтай, Ховд, Төв, Булган, Өмнөговь, Сүхбаатар зэрэг аймгуудаас ч илүү оршин суугчтай том хороо. Гэвч энд иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрх зөрчигдсөөр 20 гаруй жилийг үдлээ. Уг хороо агаарын бохирдлын хоёрдугаар бүсэд багтдаг. Шинэ суурьшлын бүс учраас хүн ам нь маш хурдацтай өсөн нэмэгдэж буй “айл”. Өдөрт дунджаар 50-100 хүн шилжиж ирдэг тул энэ хэрээр яндангийн тоо нэмэгдэж байгаа аж. Үүнийг дагаад сургууль, цэцэрлэг хүрэлцээгүй, дэд бүтэц хөгжөөгүй зэрэг олон бэрхшээл дунд иргэд амьдарч байна.

Тус хорооны өрхийн эмнэлгээр ороход хүүхдээ тэвэрсэн эхчүүд, настайчууд голдуу хүмүүс эмчид үзүүлэхээр дугаарлаж харагдав. Өвлийн улиралд энд агаар дуслаар дамждаг амьсгалын замын халдварт өвчин нэмэгддэг. Харин зун цагт гэдэсний халдварт өвчин эрс өсдөг байна. Өрхийн эмч Б.Атарцэцэг “Төв цэвэрлэх байгууламжийн үнэр хавар, намар маш хурц үнэртдэг. Хүүхэд, хөгшид гэлтгүй бүх хүний эрүүл мэндэд ямар нэг хэмжээгээр нөлөөлж байгаа. Үүнээс шалтгаалж гэдэсний халдварт өвчин нэмэгддэг. Бид жирэмсэн эхчүүдэд сургалт явуулахдаа маск тарааж, байнга хэрэглэхийг зөвлөдөг. Дөнгөж төрсөн нялх хүүхдүүд хүчилтөрөгчийн дутагдалд орох нь их болсон. Хүүхдээ аль болох цэвэр агаартай газар байлгахыг зөвлөхөөс өөр хийж чадах зүйл алга” гэв. Төв цэвэрлэх байгууламжийн лагаас маш олон төрлийн хорт бодис ялгардаг. Үүнд агуулагддаг азот, фосфор, хлорын нэгдэлд эгэл биет, вирус, шимэгч хорхойн өндөг зэрэг исэлддэг тул аммиак, нүүрсхүчлийн хий, метан зэрэг хорт бодисууд ялгарч, эвгүй үнэр үүсгэдэг юм байна. Гэвч энэ нь хүний эрүүл мэндэд хэрхэн нөлөөлж буй талаар шинжлэх ухааны үндэстэй, нарийвчилсан судалгаа алга. Өрхийн эмнэлгийнхэн ч энэ талаарх мэдлэг хомс байсан юм.

Эмнэлэгт дугаарлаж буй иргэдийн ихэнх нь ханиад, томуугаа эмчлүүлэхээр иржээ. Хөгшчүүл өмхий үнэрээс болж толгой нь өвдөж, байнга дотор нь муухайрдаг гэдгээ хэлж байлаа. Ер нь эндхийн иргэд агаарт дэгдсэн лагийн хорт бодисууд хүний биед хор нөлөөтэй гэдгийг мэддэг ч, яг ямар эрхтнийг өвчлүүлдэг, хэр их хор хохирол учруулдаг талаар тун бага мэдлэгтэй аж. “Манайх энд зургаан жилийн өмнө хотын төвөөс хол, цэвэр агаартай гэж нүүж ирсэн. Гэвч одоо өмхий агаараар амьсгалж байснаас гэртээ нүүрсээ үнэртэж байсан нь дээр гээд хүүхдүүдээ аль болох гаргахгүйг хичээдэг. Зуны бүгчим өдөр агаар оруулах гээд хаалгаа нээхээр урдаас өмхий үнэр ханхалдаг. Одоо хөл хүнд охиндоо их санаа зовох юм. Энэ өмхий үнэр ямар ч байсан эрүүл мэндэд муугаар нөлөөлж байгаа нь тодорхой. Салхи өмнө зүгээс битгий үлээгээсэй гэж залбирдаг болсон” гэж 50 гаруй насны эмэгтэй өгүүлэв.

Хороонд цэцэрлэгийн насны 2700, сургуулийн насны 8000 орчим хүүхэд байдаг. Дээр нь нэг нас хүрээгүй хагас мянган нялхас бий. Тус хорооны иргэдийн тал хувь нь залуучууд учраас төрөлт харьцангуй их байдаг аж. Өнгөрсөн жил гэхэд л 493 шинэ иргэн мэндэлсэн байна. Гэвч тэд төрсөн цагаасаа эхлээд эрүүл, чийрэг хүн болж өсөх ямар ч баталгаагүй болжээ.

Орон сууцны цонхоо хаасан ч лагийн өмхий үнэр нэвт ханхалдаг

Эрүүл мэндийн яамнаас Сонгинохайрхан дүүрэгт байрлах төв цэвэрлэх байгууламж орчмын 163 өрхийн гишүүдэд судалгаа хийжээ. Ингэхэд иргэдийн 43 хувь нь элэг, 47 хувь нь бөөрний үрэвсэлтэй гарсан байна. Түүнчлэн 90 гаруй хувь нь ямар нэг харшлын өвчтэй нь тогтоогджээ. Бохир агаараар амьсгалснаас болж, үнэрлэх, амтлах, эрхтний үйл ажиллагаа муудах, хоолой загатнах, нүд загатнаж улайх, үрэвсэх, арьсан загатнаж, туурах зэрэг эрсдэл тулгардгийг уг судалгаанд дурдсан байна.

XXII хорооны Засаг дарга Х.Тэмүгэ “Манай хороонд тог, цахилгаанаас эхлээд маш олон бэрхшээл асуудал байдаг ч иргэдийн хамгийн их гомдол гаргадаг нь лагийн үнэр. Бид тухай бүрд нь нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Улсын их хурал зэрэг холбогдох байгууллагуудад уламжилдаг. Нийслэлийн Засаг дарга өнгөрсөн намар иргэдтэй уулзсан. Ирэх хавраас төв цэвэрлэх байгууламжийн шинэчлэлийн ажлыг эхлүүлнэ гэж амласан. Тиймээс бид хэзээ ажлаа эхлэх бол, хэзээ энэ өмхий үнэрээс салах бол гэж харж, хүлээж байгаа. Бусад асуудлыг шийдэж чаддаггүй юм гэхэд ядаж эрүүл, цэвэр агаараар амьсгалах эрхийг нь иргэддээ эдлүүлмээр байна” гэлээ.

Ийнхүү хорооны иргэд энэ хавар цэвэрлэх байгууламжийн шинэчлэлийн ажил эхэлж, өмхий үнэрээс удахгүй сална хэмээн тэвчиж сууна. Тэд өдөр тутмын амьдралдаа түүртэн, хий дэмий л санаа зовохоос цаашгүй байна. “Хорин жил тэвчсэн юм чинь одоо хэдэн сар тэвчихэд яах вэ. Төр засгаас арга хэмжээ авч байгаа л гэсэн. Өмхий үнэрээс болж нүүлтээ биш. Одоо төр, засгаа л харж байна даа” гэж нэгэн буурай өгүүллээ.

Гэвч тэдний найдаж буй шинэчлэлийн ажил энэ хавартаа багтаж эхлэх эсэх нь тодорхойгүй байгаа нь тун харамсалтай. Төв цэвэрлэх байгууламжийг шинэчлэх ажлыг хариуцсан Барилга, хот байгуулалтын яамны Нийтийн аж ахуйн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга О.Лхагвацэнд “Лагийн асуудлыг шийдэх төсөв батлагдсан. Удахгүй ямар ажил хийх талаар эцсийн хариу гарна. Харин төв цэвэрлэх байгууламжийн санхүүжилтийг бүрэн шийдэж амжаагүй байгаа. БНХАУ-ын талаас эцсийн байдлаар хариу өгөөгүй. Бид энэ хаварт багтаан ажлаа эхлэхээр төлөвлөж байгаа” гэсэн бүрхэг хариулт өглөө. Уг нь төв цэвэрлэх байгууламжийг шинэчлэх төсвийг БНХАУ-ын хөнгөлөлттэй зээлээр шийдсэн хэмээн өнгөрсөн намар эрх баригчид мэдэгдэж байсан. Гэвч ийнхүү эцсийн шийд гараагүй, нэг ч бодит ажил эхлээгүй байна. Энэ хооронд төр засгийн гарыг харж, хүлээсэн иргэд бохир агаараар амьсгалж хордсоор л байх нь. Эрх баригчдын хоосон амлалтад итгэж, хордож буйгаа мэдэхгүй яваа иргэд зөвхөн энэ хорооны оршин суугчдаар тогтохгүй олон байгаа нь бүр ч харамсалтай. [ЗГМ]

ЗГМ: НЭГ АСУУЛТ

Лагийн үнэр таны эрүүл мэнд, амьдралд хэрхэн нөлөөлж байна вэ?

С.Нараа

Ер нь л хэцүү шүү дээ. Байрны цонх хаалттай байхад ч үнэртдэг болохоор хүүхэд, багачуудын дотор эрхтэн яаж байгаа бол гэж байнга санаа зовдог. Хөгшчүүд ч яахав, хүүхдүүддээ л их санаа зовж байна. Хавар, намарт бол маск зүүгээд ч нэмэргүй. Нөхцөл байдал үнэхээр хүнд байна. Бид байнга л санал гомдол хэлдэг ч нэмэр алга. Одоо төр засаг юу хийхийг хүлээж сууна.

Т.Аюурзана

Энд нүүж ирээд жил гаруй болж байна. Одоо төв цэвэрлэх байгууламжийн үнэрт бараг л дассан. Манай гэр бүлийн хувьд салхинд гарах зуслан байхгүй учраас хүүхдээ ихэнхдээ гэртээ л байлгадаг. Өмхий үнэр хавар болохоор улам нэмэгддэг. Хүүхдэдээ л их санаа зовж байна даа. Ханиад хүрсэн ч агаарын бохирдлоос болоод удаан эдгэж байгаа.

Т.Ганчимэг

Утаа, өмхий хоёроос салахын тулд зүүн зүгээс салхи үлээгээсэй л гэж хүсэх юм. Би уг нь хөдөө өссөн эрүүл, чийрэг хүн. Харин одоо ханиад, цэрнээс салахаа болилоо. Уушги муудсаны л шинж байх. Эмнэлэгт үзүүлж, эм уухаас өөрөөр эрүүл мэндээ хамгаалж чадахгүй байна. Дундаж үнэтэй маск 1500 төгрөгөөр авъя гэхэд санхүү хүнд байна. [ЗГМ]

С.ЦОГТБАЯР ЗУРЖ БАЙНА

Нийгэм

Дөрөвдүгээр төрөхийг барих хөрөнгийг шийдээрэй

2018 оны хөрөнгө оруулалтын жагсаалтад дөрөвдүгээр төрөх ороогүй

Б.Бямбасүрэн
@byambaab_zgm

Хан-Уул дүүргийн 10 дугаар хороо буюу Нисэхийн дэнж дээр 300 ортой дөрөвдүгээр төрөх эмнэлгийн барилгыг барихаар шав тавьж, араг ясыг нь босгосноос хойш долоон жил өнгөрч байна. Хүн амын хэт төвлөрлөөс шалтгаалан төрөлт жилээс жилд нэмэгдэж байгаа энэ үед ЭХЭМҮТ-ийн ачааллыг 30 хувь бууруулах дөрөвдүгээр төрөх эмнэлгийг хэзээ ашиглалтад оруулахыг нь иргэд нүдээ бүлтийтэл хүлээсээр байна.

Юуны өмнө өнгөрснийг эргэн сануулъя. 2011 онд “Нийслэл өргөө”, “Пума констракшн” компани консорциум болж, уг барилгыг богино хугацаанд барих үүрэг хүлээж, тендер хүлээн авсан. Гэвч барилгын гүйцэтгэл талдаа ороод, ердөө 54 хувьтай болоод гацчихсан. Тухайн үед барилга гацах шалтгааныг дэд бүтцийн шийдэлгүйгээс болсон гэж үзэж байсан ч үнэндээ худал байв. Учрыг нь тодруулахад, эмнэлгийн барилгыг нийт 19 тэрбум төгрөгөөр барихаар төлөвлөсөн боловч санхүүжилт нь хүрэхгүй гэсэн шалтгаанаар “Нийслэл өргөө” компани барилгын ажлыг талд нь хүргээд царцааж, төрөөс 25 тэрбум төгрөг нэмж нэхсэн. Иймээс Засгийн газар тус компанийн захирлыг мөнгө завшсан гэж үзэн шүүхэд өгч, тус компанитай байгуулсан гэрээгээ цуцалж,

Б.Ганбаяр / ЗГМ©

улмаар концессын гэрээгээр бариулах шийдвэр гаргасан юм.

Гэсэн ч концессын гэрээгээр эмнэлэг бариулах шийдвэр гараад 1.5 жил өнгөрсөн ч өнөөг хүртэл эмнэлгийн барилгын ажил огт эхлээгүй байна. Харин саяхнаас чихэнд чимэгтэй мэдээг нийслэлийн Засаг дарга С.Батболд дуулгасан юм. Тэрбээр “Засгийн газрын 122 дугаар тогтоолоор, эмнэлгийн барилгыг концессоор бариулах шийдвэр гарсан” гэсэн юм. Тиймээс дөрөвдүгээр төрөхийн эмнэлгийн барилгыг хэзээ барьж, ашиглалтад оруулах талаар нийслэлийн Эрүүл мэндийн газрын Эмнэлгийн тусламжийн хэлтсийн дарга М.Мөнхдэлгэрээс тодруулахад “Дөрөвдүгээр төрөх царцаасан барилгын жагсаалтад орсон хэвээр буй. Засгийн газрын тогтоолоор барилгын ажлыг концессын гэрээгээр барьж дуусгах чиглэл ирсэн. Гэхдээ дөрөвдүгээр төрөх рүү “Хүрээ” амаржих газрыг шилжүүлнэ. Харин “Хүрээ” амаржих газрын суурин дээр хүүхдийн эмнэлэг барихаар болсон” гэв. Гэвч энэ шийдвэр нь төрөх эмнэлгийн тоог нэмж, ачааллыг багасгах анхны зорилготой үл нийцэж байгаа юм. Үүнийг тэрбээр нэмж тайлбарлахдаа “Дөрөвдүгээр төрөхийг барихаар төлөвлөсөн долоон жилийн өмнө төрөх эмнэлэг хүрэлцээгүй байсан.

Дөрөвдүгээр төрөх рүү “Хүрээ” амаржих газрыг шилжүүлнэ

Үүнээс хойш Баянзүрх дүүрэгт “Амгалан” амаржих газар шинээр ашиглалтад орсон. Мөн “Өргөө” амаржих газрын өргөтгөлийг барьснаар төрөх ээжүүдэд ор хүрэлцэхгүй байх хүндрэл багассан. Тиймээс ханиад томууны үед хүүхдийн эмнэлэг, ялангуяа амбулатори, нэгдсэн эмнэлэг хүрэлцээгүй байдаг учраас “Хүрээ” амаржих газрын суурин дээр хүүхдийн эмнэлэг барих шийдвэр гаргасан юм. Ер нь 1987 оноос эрүүл мэндийн салбарт томоохон хөрөнгө оруулалт хийж байгаагүй. Тиймээс энэ жил өрхийн болон дүүргийн эмнэлгүүдийн барилгыг олон улсын хөнгөлөлттэй зээл, тусламжаар шинэчлэн барихаар төлөвлөсөн” гэв. “Өргөө” амаржих газар 45 ортой бөгөөд ачааллаа дийлдэггүй аж. Тэрчлэн тус газрыг дөрөвдүгээр төрөх рүү шилжүүлснээр хүн ам ихтэй Сонгинохайрхан дүүргийн иргэдэд үйлчлэх боломж бүрдэх юм байна. Дөрөвдүгээр төрөх зөвхөн төрөх эмнэлгийн чиглэлээр бус ЭХЭМҮТ шиг эх барих, нярайн тусламж үйлчилгээ үзүүлэх аж.

Гэхдээ 2018 оны улсын төсвөөр хийгдэх хөрөнгө оруулалтын жагсаалтад дөрөвдүгээр төрөхийн барилгын ажил ороогүй нь бас л анхаарал татсан асуудал болоод байна. Энэ талаар Эрүүл мэндийн яамны мэргэжилтнээс тодруулахад “Засгийн газрын тогтоол гарсан. Магадгүй 2019 эсвэл 2020 онд эмнэлгийн барилгыг барьж дуусгах болов уу” гэсэн тайлбар өгсөн юм. [ЗГМ]

Г.Билгүүн: Монголд олон улсын баталгаажилтын анхны компани төрлөө

Г.Мөнх
ЗГМ

Монголын аж ахуйн нэгжүүд дэлхийн 166 орны зах зээлд гарч өрсөлдөх зам нээгдэж байгаа сайхан мэдээг дуулгая. Манай бизнесийнхнийг гадаад ертөнцтэй холбох гүүр болсон ISO стандартын баталгаажилтыг үндэсний “МонСертф” компани олгодог болно. Энэхүү эрхийг Олон улсын итгэмжлэлийн байгууллага хэн дуртайдаа олгодоггүй. Тиймээс тус байгууллагын жинхэнэ гишүүн Казахстаны үндэсний итгэмжлэлийн төвийн удирдлагууд өнгөрсөн долоо хоногт манай оронд ирж “МонСертф” компанийн үйл ажиллагаа, чадамжийг нь нэг бүрчлэн шалгаж, танилцсан байна. Тэд ажлаа дүгнэн ярихдаа “Өнгөрсөн онд Казахстаны үндэсний итгэмжлэлийн төвд “МонСертф” компаниас удирдлагын менежментийн тогтолцоогоор олон улсын итгэмжлэл хийлгэх хүсэлт гаргасан. Бид хүсэлтийг хүлээн авч хоёрдугаар сарын 7-9-ний өдөр итгэмжлэлийн байгууллагын олон улсын ISO17021:2015 стандартын дагуу тус компанийн чадавх, байгууллагын ажиллах хүчин болон менежментийн чанарын тогтолцоог шалгалаа. Тус компанийн бүх баримт бичгийг гурав хоногийн турш шалгаж үзээд шинжээчийн эцсийн дүгнэлтээ хэлэлцсэн. Улмаар “МонСертф” компани нь олон улсын стандартын дагуу үйл ажиллагаа явуулж даган мөрддөг болохыг тодорхойлов. Шалгалтын явцад том үл тохирол илрээгүй. Харин нийт зургаан дунд болон хоёр зөвлөмжийн чанартай үл тохирол анзаарагдсан. Засах шаардлагатай үл тохиролд зориулж 10 өдрийн хугацаа өгсөн. Тайлан бэлэн болсны дараа бид бүхэн Баталгаажуулах комисстоо материалыг нь өгөх болно. Эерэг шийдвэр гаргана гэдэгт итгэлтэй байна. Учир нь энэ компанийн хамт олон бүрдэж тогтсон байна. Залуу боловсон хүчин ч байна, ахмад туршлагатай ажилтнууд ч байна. Ялангуяа, компанийн ерөнхий захирал Г.Билгүүнд удирдан манлайлах, олон улсын хэмжээний эксперт болох чадвар бүрэн байна. Бидний хийж буй итгэмжлэл, олгож буй гэрчилгээ Монголын экспортод чиглэгдсэн бүтээгдэхүүнийг гадаадад гаргах боломжийг бүрэн бүрдүүлж чадна гэдэгт итгэлтэй байна” гэлээ.

Урьд нь манайхаас MNS:ISO гэрчилгээ авсан компаниуд автоматаар 166 оронд хүлээн зөвшөөрөгдөнө.

“МонСертф” компанийн Ерөнхий захирал Г.Билгүүнтэй ярилцлаа.

-Сая Олон улсын итгэмжлэлийн байгууллагынхан ирж танай үйл ажиллагааг шалгахдаа зургаан дунд үл тохирол илэрсэн гэлээ. Ер нь үл тохирол гэж юуг хэлээд байгаа юм бэ?

-Бид Монголын аж ахуйн нэгжүүдэд аудит хийж, баталгаажуулдаг. Тухайн байгууллага үнэхээр стандартын дагуу үйл ажиллагаа явуулж чадаж байна уу гэдгийг жишээлбэл, ISO9001:2015, ISO19011 гэсэн стандартаар шалгадаг. Харин биднийг аудит хэрхэн хийж байгааг Олон улсын итгэмжлэлийн байгууллага давхар дэлхийн ISO17021:2015 гэсэн стандартаар шалгасан. Энэ стандарт нь дотроо бүлгүүдтэй байдаг. Хэрэв тэр шаардлагаас аль нэгийг нь манай байгууллага мөрдөөгүй бол үл тохирол гарна. Өөрөөр хэлбэл, үл тохирол гэдэг алдаа юм. Дотроо том, дунд, жижиг үл тохирол гэсэн гурван ангилалтай. Бага үл тохирол нь зөвлөмжийн маягтай. Сайжруулалт хийхийг зөвлөдөг. Ерөнхийдөө процессын алдаагаа аудит хийх явцдаа газар дээр нь засч, сайжруулчихлаа. Дунд үл тохирол нь гаргасан алдаагаа засах тодорхой хугацаа өгдөг юм. Харин том үл тохирол нь ямар ч найдлагагүй, шууд шалгалтдаа унана гэсэн үг. Саяын шалгалтаар манай компанид том үл тохирол илрээгүйд их баяртай байна.

-Казахстаны үндэсний итгэмжлэлийн байгууллагын өгсөн арав хоногийн хугацаанд дунд үл тохирлоо арилгачихвал олон улсын баталгаажуулалтын эрхээ албан ёсоор авна биз дээ?

-Тийм ээ. Манай компани дээр гарсан үл тохирлуудыг бид нааштайгаар хүлээж авч байгаа. Олон улсын үнэлгээ гэхээсээ илүү байгууллагын сайжруулалт гэж харж байна. Ингэснээр манай компани улам чадваржина. Цаад үр дүн нь манай хэрэглэгч, үйлчлүүлэгчдэд байнгын сайжруулалт хийгдээд явах юм. Энэ бол том давуу тал.

-“МонСертф” компани хэдэн онд байгуулагдсан бэ. Та бүхэн олон улсын итгэмжлэлийн байгууллага болохын тулд хэр их хугацаа зарцуулав?

-Манай компани 2016 онд байгуулагдсан. Тэр үедээ л олон улсын баталгаажилтын байгууллага болно гэсэн том зорилго тавьсан. ISO стандартын баталгаажилтыг аж ахуйн нэгжүүдэд өгөхийн тулд бид өөрсдөө олон улсын стандарт мөрдөнө. Иймд нэн түрүүнд боловсон хүчнээ бэлдэж эхэлсэн. Монгол Улсын хэмжээнд туршлагатай 30 аудиторыг сургаад, олон улсад хүлээн зөвшөөрүүлж, бүртгэлийн процессыг нь явуулаад баталгаажуулсан. Бид бүхэн гадаад хамтын ажиллагааныхаа хүрээнд Туркийн “АНКА глобал” консорциум, Францын “AFNOR” групп, БНХАУ-ын “UICC” групп зэрэг олон улсын баталгаажилтын байгууллагатай хамтран ажилладаг. Гэрээний дагуу AFNOR группийн нэрийн өмнөөс таван байгууллагад аудит хийж, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн долоон гэрчилгээг олгоод байна. Энэ хэрээр манай аудиторууд бэлтгэгдэж, зэрэг нь ч өссөн байгаа. “МонСертф” компани өнгөрсөн жил үндэсний итгэмжлэл авсан. Ингээд олон улсын итгэмжлэл авахад бэлэн болсон гэж үзээд 2017 оны есдүгээр сард Казахстаны үндэсний итгэмжлэлийн байгууллагад хүсэлтээ тавьсан. Тэд манай компанийг зургаан сарын турш судалж, сая шийдвэрээ гаргалаа. Энэ хугацаанд бид бүх журмуудаа олон улсын стандартад нийцүүлэхийн тулд идэвхтэй бэлдсэн. Нөр их хүч, хөдөлмөр орсон. Нийт зургаан ажлын хэсэг гаргаж, хоёр жил бэлдсэн ажил маань үр дүнгээ өгч байгаад үнэлгээний баг хамт олондоо баярлалаа.

-Танай компани олон улсын ISO стандартын гэрчилгээг олгож эхэлбэл Монголдоо анхдагч нь гэж ойлгож болох уу?

-Тийм ээ, үндэсний хэмжээнд олон улсын баталгаажилтын байгууллага төрчихлөө гэсэн үг. Баталгаажилтын хувийн салбар Монголд ерөөсөө хөгжөөгүй. Тиймээс манай компани салбартаа түүчээлэн ажиллана. Хоёрдугаарт, чанарын дэд бүтэц бий болно. Ингэснээр Монголын аж ахуйн нэгжүүд ISO стандартыг олон улсын, гадаадын байгууллагаас биш дотоодоос авах боломж бүрдэж байна. Гуравдугаарт, монгол аудиторууд олон улсын стандартын дагуу үндэсний компаниар баталгаажуулдаг болох юм. Ингэснээр олон улсын ISO гэрчилгээг хямд өртгөөр авах боломжтой. Урьд нь ISO гэрчилгээг гадны хүн хийдэг байсан бол одоо Монгол аудитор хийдэг болсон байгаа. Урьд нь гадагшаа роялти төлдөг байсан бол Монголдоо татвар төлөгддөг болсон. Гадны аудитор цалин авдаг байсан бол монгол аудитор цалин авна.

-Тэгэхээр гадны байгууллагаар баталгаажуулж ISO стандарт авахын тулд ямар үнэ төлбөртэй байдаг юм бэ?

-Манай менежмент сайтай компаниуд ISO стандартыг авсан байдаг. Тэд гадны байгууллагад 10-30 мянган ам.доллар төлдөг. Харин Монголдоо үндэсний баталгаажилтын төвтэй болсноор энэ мөнгө 4-5 дахин хэмнэгдэнэ. Орчуулгын зардал ч танагдана. Олон улсын баталгаажилтыг авна гэдэг нь манай аж ахуйн нэгжүүдэд санхүүгийн хувьд хүнд. Нэг удаа баталгаажуулалт аваад гэрчилгээтэй болно гэдэг нэг асуудал. Харин энэ гэрчилгээгээ жил бүр баталгаажуулах ёстой. Тэгэхээр дахиад л гадны баталгаажилтын компани авчирч, өндөр зардал гаргах хэрэгтэй болдог. Жил болгон гадны аудитор нь өндөр өртөгтэй томилолтоор ирдэг. Тэр нь урт хугацаатай байх юм бол ISO стандартын гэрчилгээ нь тухайн компанид экспорт хийхэд нь нэмэр болно гэхээсээ илүү нэрмээс болоод байсан талтай. Энэ асуудлыг “МонСертф” компани дотооддоо шийднэ. Аж ахуйн нэгжүүдэд хэлэхэд одоо гадаадын аудиторуудыг шүтдэг цаг ард хоцорч байна.

-Өмнө нь гадны байгууллагын баталгаажилтаар ISO стандарт авсан үндэсний компаниуд жил бүрийн сунгалтаа танайхаар хийлгэж болох уу?

-Олон улсынхаа гэрчилгээнүүдийг шууд “МонСертф”-рүүгээ шилжүүлж болдог нөхцөл боломж бүрдлээ. Ингэж давхар үндэснийхээ аудиторуудыг дэмжих хэрэгтэй. Стандартууд адилхан.

-Танай компани ISO стандартыг баталгаажуулдаг болсноор Монголын бараа бүтээгдэхүүн дэлхийн бүх орны зах зээлд саадгүй нэвтрэх боломжтой болох нь ээ?

-Тэгэлгүй яахав. Одоо MNS стандарт ганцхан манай оронд хүчин төгөлдөр байгаа. Тэгвэл ISO стандарт дэлхийн 166 оронд хүлээн зөвшөөрөгдөнө гэсэн үг. Урьд нь манайхаас MNS:ISO гэрчилгээ авсан компаниуд автоматаар 166 оронд хүлээн зөвшөөрөгдөнө. Хамгийн чухал нь гадны хөрөнгө оруулалтыг татах, гадагшаа IPO хийх боломжтой.

Дашрамд дурдахад, үндэсний болон олон улсын итгэмжлэлийн байгууллагууд биднийг үнэлээд чадвартай гэдгийг нотолчихлоо. Стандарттай Монгол болохын төлөө манай байгууллага ажиллаж байна.

[ЗГМ СОНИН]

“Засгийн газрын мэдээ” сонин нь ардчилсан, шударга ёс, хүний эрхийг дээдэлж, чөлөөт сэтгүүл зүйн хэм хэмжээг бүрнээ сахин, олон ургальч үзлийг илэрхийлэх мэдээллийн индэр байж, нийт Монгол үндэстний ойлголцол, эв нэгдлийг бэхжүүлэхийг эрхэм зорилгоо болгоно.

ТУЗ-ийн дарга
Эрдэнэбаатарын ДОЛГИОН

Ерөнхий эрхлэгч
Баатарын ДУЛАМХОРЛОО

Зөвлөх
Шатарбалын ДАВААДОРЖ

Орлогч эрхлэгч
Лхагважавын СУГАРМАА
Утас: 99903584

РЕДАКЦ

Улс төр, нийгэм, эрэн сурвалжлах мэдээллийн алба
Эдитор Б.Даваатогтох
Утас: 99901637

Эдийн засаг, уул уурхайн мэдээллийн алба
Эдитор Б.Баяртогтох
Утас: 99901532

Цахим контент, бүтээлч үйлдвэрлэлийн алба
Эдитор Г.Баярсайхан
Утас: 99903574

ЗАР СУРТАЛЧИЛГАА

Утас: 99903581
99903578
99909472
99907843

ХАЯГ

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
I хороо, Энхтайваны өргөн чөлөө,
“Блю Скай тауэр” 407 тоот
Улсын бүртгэлийн дугаар. 1024
Утас: 70103131,
Факс: 7010606

ЦАХИМ ХУВИЛБАР

ubinfo.mn

Дугаарын удирдагч
Л.Сугармаа

8 658000 029112 00835

ЗГМ: Зочин

Г.Мөнх-Очир: Нислэгийн бүх дүрэм журам цусаар бичигдсэн байдаг юм

15 мянган цагийн нислэг хийж, хоёр жил гаруй хугацааг агаарт өнгөрүүлжээ

"Хэрэв нисэхээс айж байгаа бол онгоц руу зүглэх ч хэрэггүй" гэж би шавь нартаа хэлдэг. Харин айдасгүй байхын тулд өөрийгөө бэлдэх ёстой. Гэхдээ айхгүй байна гээд бардаж болохгүй.

◀1

Бид нэг талдаа дүүрэн хүн зөөж, буцахдаа хоосон шахуу нисдэг байлаа.

Өвөл жуулчны тоо багасдаг учраас манай компани сул зогсолт их хийдэг. Тиймээс өвөл нойтон түрээсээр явбал нислэгийн дадлага алдагдахгүй, компанид ч санхүүгийн хувьд ашигтай. Манайх өнгөрсөн жил Мальдивын арлуудаас Бээжин, Шанхай, Гуанжоу руу нислэг хийж байсан.

-Өмнөд Америкийн халуун дулаан уур амьсгал нислэгт нөлөө үзүүлэх үү?

-Монгол, Хятад, бусад улсад ч ялгаагүй цас, бороо, салхи шуурга гээд цаг агаарын бүхий л үзэгдэл байдаг. Гэхдээ тухайн орны онцлог гэх зүйл бараг байхгүй дээ. Яахав, Япон, Хонконг зэрэг улсад жилдээ хэд хэдэн удаа далайн том шуурга болдог. 30-40 метр секунд хурдтай салхилахаар нислэгээ хойшлуулахаас аргагүй шүү. Манайд ч хаврын улиралд нөхцөлгүй салхилах тохиолдол бий. Их салхинаас болоод нислэг саатах тохиолдол зөндөө л гардаг. Ялангуяа, сүүлийн жилүүдэд манай цаг агаар тогтворгүй болоод байгаа.

-Утаанаас болоод харагдах орчин хязгаарлагдаж, бууж чадаагүй тохиолдол байна уу?

-Утаанаас болоод нислэг саатах тохиолдол харьцангүй гайгүй. Гэхдээ нислэгт хүндрэл учруулалгүй яахав. Ялангуяа, шөнийн цагт харагдах орчныг маш их хязгаарладаг. Ид гал түлээд эхэлсэн үед буухад хэцүү шүү. Ердийн үед 18 орчим километрээс буух зурвасаа хардаг бол утаа ихтэй үед 5-6 километр ойртож байж л харагдана. Манай аэродромын хязгаарт утаа 1600 метрээс доош байвал бууж болно гэсэн заалттай. Харин хэдэн жилийн өмнө Сингапураас шөнө ирж явахдаа Улаанбаатарын агаарын мэдээ авахад утаа 6000 метр өндөртэй байна гэсэн. Тиймээс Бээжинд хоноод маргааш нь ирсэн тохиолдол бий.

-Хоёулаа ярианыхаа сэдвийг бага зэрэг өөрчилье. Хөвгүүдийн хувьд нисгэгч гэдэг мөрөөдлийн мэргэжил нь байх. Та багадаа нисгэгч болохыг хүсэж байв уу. Яагаад энэ мэргэжлийг сонгосон юм бэ?

-Би Хөвсгөлийн Мөрөн хотын нэгдүгээр сургуулийг төгссөн хүн. Аав, ээж маань малчин хүмүүс. Багадаа нисгэгч болно гэж мөрөөдөөгүй ээ. Арван жилдээ сурлага сайтай л хүүхэд байлаа. Математикийн хичээлдээ илүү сайн болохоор тэр чиглэлээрээ сурна гэж бодож байсан ч хувь заяа өөрөөр шийдсэн юм. Тухайн үед гадаадад очиж сурах нь хүүхэд бүрийн мөрөөдөл байлаа. Гэтэл намайг төгсдөг жил Орост нисгэгчийн ангид сурах хуваарь ирж таарсан юм. Ингээд хуучнаар ЗХУ, одоогийнхоор Украины Нисэхийн дээд сургуульд дөрвөн жил хагас сурсан.

Би багадаа техник талдаа сонирхолтой хүүхэд байсан. Элдэв юм засах дуртай. Харин нисэхийн сургуульд техникийн хичээл үзээд эхэлсэн нь сонирхолтой санагдсан. Тэгээд дараа нь нисэж эхэлсэн. Эхэндээ хүндрэл гаралгүй яахав. Баруун, зүүнээ мэдэхгүй ногоон толгой чинь их л үзэж тарна. Энэ хооронд хөөрч, буух гээд зөндөө дадлага хийж байгаа юм. Нисэх болгонд багш хажууд сууж, бүгдийг зааварчилдаг байлаа. Тэр үеийн оросууд хүнд юм сургахын төлөө гэсэн сэтгэлтэй сайхан хүмүүс байж.

-Монголоос хэдүүлээ очсон бэ?

-Дөрвөн хүн байсан. Одоо дөрвүүлээ сайхан нисэж байна. 1989 онд шижигнэсэн дөрвөн залуу төгсч ирснээс хойш бараг 30 жил өнгөрчээ. Цаг хугацаа ч хурдан юм аа.

Монголдоо ирээд Ан-24 онгоцны хоёрдугаар нисгэгч хийж байгаад 1992 онд Ан-26 онгоцны дарга болсон. Тэгээд 1993 онд Боинг-727 онгоцны хоёрдугаар нисгэгч, 1997 онд онгоцны дарга нь болсон. 1998-2010 он хүртэл Аэробус-310 онгоцны даргаар ниссэн. 2011 оноос хойш Боинг-767 онгоцны дарга хийж байна даа.

-Анх удаа бие дааж нисэхэд ямар санагдаж байв?

-Мэдээж айдас байлгүй яахав. Гэхдээ хэт их айгаад байвал хүн нисч чадахгүй шүү дээ. 50 хувь айдас байхад 50 хувь өөртөө итгэх итгэл байна. Харин нисээд ирсний дараа бол сайхан л даа. Хүн болгон ирж баяр хүргээд бөөн юм болно. Ер нь бие даагаад ниссэний дараа "Би чадах юм байна" гэсэн итгэл төрдөг юм.

Гэхдээ хүн хэзээ ч мундаг нисгэгч болчихлоо гэж тайвширч болохгүй. Бид одоо ч суралцсаар л байна. Байнга шалгалт өгнө. Та нар намайг жилд хэдэн шалгалт өгдөг гэж бодож байна. Нислэгийн, баруун, зүүн суудлын шалгалт өгнө, бүхээгийн дадлага хийнэ. Дээрээс нь англи хэлний шалгалт өгнө. Бид хамгийн багадаа нисэхийн англи хэлний дөрөвдүгээр түвшинд байх ёстой. Над мэтийн хүн бол дөрвийг нь авах гэж чардайна шүү дээ. Сүүлд англи хэл сурсныг ч хэлэх үү. Дээр үед орос хэлтэй л бол хангалттай гэж боддог байж. Юун Гайти, Чилид очиж нисэх. Тэр тухай төсөөлөөгүй л байхгүй юу. Нэгэнт шаардлага нь юм болохоор амьдралын эрхээр сурч байгаа юм. Гэхдээ дөрөвдүгээр түвшинтэй хүн гурван жил болоод дахин шалгалт өгөх ёстой.

-Социализмын үед улс бүх зүйлийг нь хангаад амар байсан байх. Харин зах зээлд шилжсэний дараах үеийн нөхцөл байдал ямархуу байсан бэ?

-1989 онд төгсөж ирсний дараахан ардчиллын салхи улс орон даяар сэвэлзэж байлаа. Тэгээд 1990 он гарсны дараа бужигнаад явчихсан. Гэхдээ манай МИАТ шилжилтийн шуурганд айхтар өртөөгүй юм шүү. Буянт-Ухаа чинь үнэхээр буянтай газар байгаа юм. Манай дээдэс нэр усыг нь өгөхдөө хүртэл айхтар бодолцсон байдаг. Их эртнээс ийм нэртэй байсан шүү дээ.

Мэдээж зах зээлийн шуурга тодорхой хэмжээгээр нөлөөлөлгүй яахав. Гэхдээ цалингаа тавьж чадахгүйд хүрэх, нислэггүй болох зэргээр таг зогсчихоогүй ээ. Тухайн үеийн удирдлагууд ч сайн ажилласан байх. Манайхан 1990-ээд оны эхээр наймаанд мундаг явсан. Тиймээс Улаанбаатар-Бээжингийн нислэг хүн ихтэй. Түүнчлэн Япон, Солонгостой харилцаа сэргэхтэй зэрэгцээд жуулчид их ирдэг болсон. Бид жуулчид авах гэж Японы мөн ч олон хот руу ниссэн дээ. Энэ бүхэн МИАТ-ийн санхүүд сайнаар нөлөөлсөн байх.

-Та нийт хэдэн нислэг хийснээ тооцож үзсэн үү?

-Одоогоор 15 мянган цаг нисээд байна. Жилээр нь тооцвол хоёр жил гаруй хугацааг агаарт өнгөрүүлжээ.

-Та олон ч нисэх буудалд газардсан байх. Үнэхээр өндөр зэрэглэлийн, хамгийн сайн буудал аль нь байв?

-Сингапур, Инчоны нисэх буудал мундаг шүү. Үйлчилгээ, тав тухтай орчин бүрдүүлсэн байдал, нислэгийн удирдлага зэрэг нь үнэхээр мундаг. Нисгэгч нарт ч амар, зорчигчдод ч таатай байдаг юм. Ер нь анзаараад байхад манай Азийнхан сайн. Америк, Европынхон хүнд үйлчилж буй байдал, хүн чанар зэргээрээ Азийнхныг гүйцэхгүй.

Энгийн хүмүүст нисгэгч болох боломж олдохгүй байна гэдэг үнэн

-Хамгийн удаандаа хэдэн цаг нисч байв?

-Сиэтлээс Улаанбаатар хүртэл 12 цаг 30 минутын шууд нислэг хийж байсан. Бидэнд нислэгийн үеийн дүрэм бий. Дүрэмд зааснаар тухайн нислэгт есөн цагаас илүү хугацаагаар нисч болохгүй. Хэрэв удаан нисэхээр бол заавал нэмэгдэл нисэгчтэй явдаг. Бид Улаанбаатараас Америкийн Нью Мексико руу онгоц хүргэхээр 15 цагийн нислэг хийхэд хоёр экипаж явж байсан.

Ер нь онгоцны нисгэгч маш их дүрэм журамд баригддаг. Нислэгээс тэдэн цагийн өмнө архи ууж болохгүй, донор хүн цусаа өгвөл 72 цаг нисч болохгүй гэх зэргээр дүрэм журам маш их. Олон хүний аюулгүй байдлыг хангаж явах үүрэгтэй болохоор хатуу дүрэмтэй байхаас ч аргагүй. Энэ бүх дүрмийг цусаар бичсэн юм гэж манай ахмадууд ярьдаг. Яагаад гэвэл нэг осол гарах бүрт дүн шинжилгээ хийж, юун дээр алдав гэдгийг тодорхойлсноор дүрэм журмаа шинэчилж байдаг юм. Үүнийг огт зөрчиж болохгүй. Энэ бүх дүрэм журам биднийг нисгэгч болгон хүмүүжүүлдэг.

-1990-ээд онд онгоцны том осол ойр ойрхон гардаг байсныг санаж байна. Тухайн үед үнэхээр азгүй тохиолдол болсон уу, эсвэл манайхан ажилдаа хайнга ханддаг байв уу?

-Тэр үед манай тоноглол муу байсан. Газрын тоноглол муу болохоор нислэгийн хөдөлгөөний удирдагч тухайн онгоцыг харахгүйгээр удирдана. Үүнээс болж осол гаргасан нисгэгч нар чигийн баримжаагаа алдсан байдаг. Харин GPS нэвтэрснээр том осол харьцангуй цөөрсөн. GPS-ийг америкчууд 1980-аад оны сүүлээр, оросууд 1990-ээд оны эхээр, Монголд 1990-ээд оны дундуур нэвтрүүлсэн. Энэ технологийг ашигласнаар хүнээс хамааралтай алдааг багасгасан.

-Та өөрөө онц аюултай нөхцөл байдалд орж байв уу?

-Бурхны авралаар гайгүй дээ. Жижиг сажиг юм тохиолдсоноос болж буцаж буух зэрэг асуудал мэр сэр байсаан.

-Хэдийгээр 30 шахам жил ниссэн ч гэлээ 200 гаруй хүний амь насыг хариуцаад нисэхэд айдас төрдөг байх. Энэ бүхэн сэтгэл зүйд яаж нөлөөлдөг вэ?

-Сурчихсан болоод ч тэр үү, сэтгэл зүйд нөлөөлөх нь гайгүй ээ. Мэдээж тэр олон хүнийг зорьсон газар нь аюул осолгүй хүргэхийг хэн ч бодно. Би ч өөрөө гэр бүл, үр хүүхэдтэй хүн шүү дээ. Тиймээс цаг агаар сайхан байгаасай, аюул осол холуур байгаасай гэж мөнгөн онгоц, мөнх хөх тэнгэртээ залбирч явдаг юм.

Одоо надад арав гаруй шавь байна. Би шавь нартаа "Та нар нисэхээс айж байгаа бол онгоц руу зүглэх ч хэрэггүй" гэж хэлдэг. Хүн айгаад байвал гар хөл нь чичрээд тэр нислэгийг амжилттай хийж чадахгүй. Тиймээс айдасгүй байх ёстой. Харин айдасгүй байхын тулд өөрийгөө бэлдэх ёстой. Гэхдээ айхгүй байна гээд бардаж болохгүй.

С.Батсайхан / ЗГМ©

-Урт нислэгийн үед онгоцны бүхээг дотор цагийг яажшуухан өнгөрүүлдэг нь сонирхолтой санагдаад байдаг юм?

-Суугаад сурчихдаг юм даа. Дундуур нь ганц нэг удаа бие засаж, хэд суниаж аваад л суунa. Мэдээж хүн л юм болохоор хоорондоо юм ярина. Гэхдээ сүүлдээ ярих юм ч олдохоо больчихдог юм (инээв). Хааяа нойр хүрээд байвал сайхан дуу аялчихаар сэргээд ирнэ.

-Шинэ нисэх буудал оны төгсгөлөөр ашиглалтад орох байх. Энэ мөчийг та бүхэн тэсэн ядан хүлээж байна уу?

-Шинэ нисэх буудал нисгэгч нарт сайхан боломж өгнө. Цаг агаар муу үед хоёр талаасаа буучихна. Харин энгийн зорчигчдын хувьд хол шүү дээ. Манайхан нэгнийгээ Солонгос явахад гэр бүлээрээ гаргаж өгдөг улс. Харин одоо тийш давхисаар байтал нэлээд явдал болох байх. Хоёрдугаарт, энэ буудлыг ашиглалтад автал зардал нэлээд гарна. Тиймээс хувийн ч бай, хувьсгалын ч бай компаниудад санхүүгийн нэлээд дарамт ирэх юм шиг байна лээ.

-Хүнд унах дуртай машин гэж байдаг. Тэгвэл ямар онгоц жолоодох хамгийн дуртай вэ?

-Нисгэгч хүн унасан хөлгөө муулдаггүй юм. Миний нисч байсан онгоц бүхэн сайхан, надад хишиг буянаа хайрласан. Онгоц болгон жолоодлого, тоноглол, ажиллах процедурын хувьд өөр. Өөр онгоц жолоодох бүрт шинэ юм сурч байдаг.

Онгоц томрох тусам тогтвортой сайхан болж ирдэг. Гэхдээ томрох тусмаа хүний алдааг илүү тод гаргаж ирдэг. Жолоодлого дээр алдаа гаргавал үр дүн нь илүү аюултай байх болно. Бид Улаанбаатарт 200 гаруй км цагийн хурдтай газардаж байна. Ийм өндөр хурдтай буух үед өчүүхэн төдий алдаа гаргахад л өршөөхгүй шүү дээ.

-Та жилийн 365 хоногийн хэдэд нь гэртээ, хэдэд нь гадуур нислэгтэй байдаг вэ?

-Гуравны нэгд нь гадагшаа явж таардаг байх шүү. Гэхдээ өдрөөр явбал оройдоо буцаад ирнэ. 07.30-д Сөүлийн нислэгтэй бол өглөө 05.00 цагт босч яваад орой буцаад ирчихнэ.

-Таны үед улс нисгэгчдээ бодлогоор бэлддэг байж. Харин одоо залгамж халаагаа хэрхэн бэлдэж байна?

-Хүүхдүүд ихэвчлэн Америкт хувиараа сурч байна даа. Нисгэгч болоход бас л том шаардлага тавина шүү. Жишээ нь, МИАТ-ийн Боинг онгоцны хоёрдугаар нисгэгч болохын тулд 1500 цаг ниссэн байх ёстой. Энэ цагаа гүйцээхийн тулд жижиг онгоцуудаар нислэг үйлдэнэ гэсэн үг.

-Одоо баян айлын хүүхдүүд л нисгэгч болж байна, энгийн хүмүүст ийм боломж олддоггүй гэж шүүмжилдэг. Энэ хэр бодитой шүүмжлэл вэ?

-Яг үнэн. Нисгэгч болохын тулд 100 гаруй мянган доллар гаргах айл хэд билээ. Тэгэхээр энгийн хүмүүст боломж олдохгүй байна гэдэг яах аргагүй үнэн. Социализмын үед бол улс бодлогоор бэлддэг байлаа. Намайг нисэхийн сургуульд элсдэг жил Баян-Өлгийд хүртэл нэг хуваарь очиж байв. Одоо бол тийм бодлого алга. Төр маань ч нисгэгч бэлдэх боломж тааруу байх шиг байна. Тиймээс чиний хэлдгээр мөнгөтэй айлын хүүхдэд л нисгэгч болох нөхцөл бүрдчихсэн. Үүнийг ойрын хэдэн жилдээ өөрчилж чадахгүй биз дээ.

-Та нарын залгамж халаа хэр бэлтгэгдсэн бэ?

-Нэг хэсэг тасрах шахсан, одоо гайгүй шүү. Одоо МИАТ-ийн нисгэгчдийн тал хувь нь 40-өөс доош насныхан. Сүүлийн хэдэн жил маш их залуужиж байгаа.

Би өөрийнхөө ганц хүүг нисгэгч болгоогүй. Уг нь надад албан тушаал, боломж бололцоо нь байсан. Гэвч дараа нь болъё гэсээр байгаад хүүгээ гомдоосон доо. Нэрэлхүү, шударга зангаасаа болоод хүүгийнхээ хүслийг биелүүлж чадаагүй юм. Гэхдээ би албан тушаалаа ашиглан ойр дотныхондоо давуу тал олгож болохгүй гэж боддог. Мөнгө, танил талаар бүхнийг шийддэг үзэгдэл Монголд хавтгайрчихаад байна шүү дээ.

-Та оны өмнөхөн гавьяат хэмээх эрхэм хүндтэй цол хүртсэн. Энэ мэдээг сонсоод юу бодогдож байв?

-Шинэ жилийн өмнө хэдэн хүүхдэдээ бэлэг авах гээд дэлгүүрт явж байтал утас дуугарлаа. Ерөнхийлөгчийн Тамгын газраас ярьж байна. "Та нөгөөдөр гавьяатын цол тэмдгээ авна. Төрийн ордонд ирээрэй" гэдэг юм билээ. Тухайн үед элдэв юм бодоогүй ээ. Эхнэр л нэлээд уйлсан байх. Тэгээд удалгүй хүмүүс утасдаад баяр хүргэж эхэлсэн. Яг Ерөнхийлөгчөөс шагналаа гардаж байхад аав, ээж минь амьд байсан бол… гэж бодогддог юм билээ. Дараа нь "Сайн хамт олны хүчээр чи энэ шагналыг авсан. Өөртөө эрдэх юм байхгүй шүү" гэсэн бодол орж ирсэн. Хамт олон, сайн хань, гэр бүлийн минь л буян юм даа. Энэ дашрамд хэлэхэд нисгэгч хүнд гэр бүлийн байдал хамгийн чухал. Гэр бүл тогтвортой, найдвартай байна гэдэг нислэгийн аюулгүй байдалд хамгийн их нөлөөтэй.

-Сайхан ярилцсанд баярлалаа. [ЗГМ]

Зах зээл

Нүнжиг, буян дүүрэн Монголын цагаан сар

Энэ төрлийн бүтээгдэхүүний борлуулалт баяр, наадмын үеэр идэвхждэг

Г.Байгал
@baigalZGM

Сүр ихт зааны толгойгоор хөл хийж, тэнгэр, газрын дөрвөн хүчтэн луу, хангарьд, арслан, барын дүрсээр чимэг нэмсэн идээний цар, ууцны суурь. Амсар, хөвөөг нь угалз хээгээр эмжсэн цайны домбо, айргийн хул… Нүүдэлчдийн зан заншил, зочломтгой зангийн илрэл болсон ахуйн эд хэрэглэл орчин цагт эргэн хэрэглээнд нэвтэрч, худалдаанд гарч байна. Нэгэн хэсэг нийтийн хэрэглээнээс хөндийрч, мартагдах дөхөөд байсан эдгээр соёлын өвийг шинэ цагийн түүхий эд, тоноглолоор чанар нэмж, монгол урчуудын уран яруу хийцээр өнгө зассан нь энэ.

Цар, домбо зэрэг ахуйн хэрэглэлүүд өдгөө үнэт эдлэлийн дэлгүүр, лангуунуудад өрөөстэй харагдах болсон. Аж ахуйн нэгж, уран дархад энэ чиглэлийн үйлдвэрлэлээ эрчимжүүлж, бүтээн туурвиж байна. Зах зээлийн эрэлт эргэн сэргэснээс зөвхөн энэ төрлийн эдлэл хэрэглэл бүтээдэг уран дархан, борлуулдаг дэлгүүр, худалдааны төв олширчээ. Одоогоор мөнгөн аяганаас гадна ахуйн эд хэрэгслийг үйлдвэрлэдэг, томоохон хэмжээний 4-5 аж ахуйн нэгж бий. Үүнээс гадна, хувиараа үйлдвэрлэдэг жижиг өрхийн үйлдвэрлэлүүд ч цөөнгүй байдаг аж. Энэ төрлийн бүтээгдэхүүний борлуулалт баяр, наадмын үеэр идэвхжиж, эрэлттэйд тооцогддогийг “Зоос гоёл” компаниас мэдээлж байна. Тус компани таван тансаг идээ агуулах зориулалт бүхий эд хэрэгслийг багцаар нь үйлдвэрлэж байна. Өнгө хосолсон “Таван тансаг” багцад зэвэрдэггүй гангаар хийж, алтаар шарсан цайны домбо, идээний цар, ууцны суурь багтаж байгаа. Үүнээс гадна сайн чанарын шил, алтлаг суурийг хослуулсан, буузны таваг, алтадмал, гуулин дөрвөн хос аягатай, 999-н сорьцтой алтадмал, сархадын домбо багтаж байгаа аж. Зоогийн ширээнд нүнжиг нэмэх эдгээр эдлэлийн багц 1.87 сая төгрөгийн үнэтэй. Нэг бүтээгдэхүүн нь дунджаар 160-450 мянган төгрөгийн үнэтэй байна. Биднийг сурвалжилга бэлтгэхээр очиход нэгэн эмэгтэй настай ээждээ сар шинийн бэлэг болгон өгөхөөр “Таван тансаг” багцаас худалдан авч байв. Худалдан авагчдын багагүй хэсэг нь бэлэг дурсгалд зориулан энэ төрлийн бүтээгдэхүүнийг сонгодог болохыг худалдагчид хэлж байлаа. Нийт худалдан авагчдын 50 хувь нь ямар нэг бэлэг, сэлтийн зориулалтаар авдаг байна.

Харин өөрийн хэрэглээнд сонгохдоо үнэт, ховор эдлэлээс илүү зэс болон мөнгө, зэвэрдэггүй ган, модон эдлэлийг илүүтэй сонирхдог. Энэ төрлийн түүхий эдээр хийсэн бүтээгдэхүүн нь үнийн хувьд ч боломжийн байдаг нь сонгох нэг шалтгаан болдог байна. Тодруулбал, алт, мөнгөөр шарж гууль, зэс, ган төмрөөр хийсэн эдлэл 100-450 мянган төгрөгийн хооронд бол модон цар, суурь 35-50 мянган төгрөгийн үнэтэй байна. Гэхдээ цул мөнгөөр хэрэглэл хийлгэх хүсэлт ирдэг байна. Үүнээс гадна модоор хийж, мөнгөөр чимэглэсэн цар гэхэд гурван сая төгрөгийн үнэтэй байна.

Эртнээс монголчууд энэ төрлийн эдлэл хэрэглэлийг гоёл, гангараа болгохоос гадна эрүүл мэндэд тусыг нь эрхэмлэсээр ирсэн. Энэ хандлага ч өдгөө үед уламжлагдаж, иргэд зэс, мөнгөн эдлэлийг илүүд үздэг байна. Зэс гэхэд хүний таван цул эрхтэн, ясны сийрэгжилтийн эсрэг, дархлаа дэмждэг байна.

Гэхдээ цагаан сар зэрэг тэмдэглэлт өдрүүдэд хэрэглэдэг, зөвхөн гангараа төдий бус өдөр тутам хэрэглэж байж үр ашгийг нь хүртдэг байсан талаар удам дамжсан уран дархан “Талст-Урлан” компанийн захирал О.Мөнгөнцоож хэлж байлаа.

Тухайлбал, зөвхөн гууль, зэсээр дагнан домбо болон аяга бүтээдэг үйлдвэрлэгч байна. Таван гуулин домбо болон таван аяганы багц гэхэд 781 мянган төгрөгийн үнэтэй. Энэ төрлийн уран дархан Л.Мөнх-Алдар аялалд авч явах зориулалттай зэс домбо хийхээр зорьж байна. Тэрчлэн домбыг орчин үетэй хослуулж, халуунаа хадгалах боломжтой байдлаар хийж эхэлж. Ингэснээр домбыг өдөр тутам хэрэглэхэд илүү таатай болсны зэрэгцээ эрэлт, хэрэглээ нь нэмэгдсэн байна.

Энэ төрлийн эдлэл нь онцгой баяр, тэмдэглэлт өдрүүдийн ширээний чимэг болоод зогсохгүй үеэс үе дамнан өвлөгдөх үнэ цэнэтэй хөрөнгө болохыг тэрбээр хэлж байна. Өөрөөр хэлбэл, нэг талаас урлагийн бүтээл, эдлэл хэрэглэл, нөгөө талаас мөнгөн хөрөнгөө хадгалах нэг хэлбэр. Тухайлбал, 2007 онд авсан гинж тухайн үед нэг гр алт 40-50 мянган төгрөгийн үнэтэй байсан бол өдгөө хоёр дахин өсөж, 110-120 мянга болчихоод байгаа. Өөрөөр хэлбэл, энэ нь үнэ цэнэ нь өсдөг хөрөнгө аж.

- **Зоогийн ширээнд нүнжиг нэмэх эдлэлийн багц 1.87 сая төгрөгийн үнэтэй.**
- **Нийт худалдан авагчдын 50 хувь нь ямар нэг бэлэг, сэлтийн зориулалтаар худалдан авдаг байна.**
- **Энэ төрлийн эдлэл нь үеэс үе дамнан өвлөгдөх үнэ цэнэтэй хөрөнгө болдог.**

Ийнхүү орчин цагт улам эрчээ авч буй эрэлттэй зэрэгцээд зарим сорилтууд тулгарч байна. Тухайлбал, энэ төрлийн бүтээгдэхүүний эрэлт нэмэгдэж буйгаас урд хөршөөс хуурамч нийлүүлэлтийг нэмэх болжээ. Гэхдээ урд хөршийн бүтээгдэхүүн нь үнийн хувьд хямд боловч түүхий эд, ур хийцийн хувьд дотоодын бүтээгдэхүүнийг гүйцэхгүй төдийгүй эдлэгээ даадаггүй болохыг ч уран дархад хэлж байлаа. Гаалийн ерөнхий газрын мэдээллээр 2017 оны байдлаар Монгол Улс 30 орчим сая ам.долларын шилэн лонх, сав, домбо, ваар, хилийн чанадаас импортолсон байна. Эртнээс ур, хийцээрээ гайхагдаж ирсэн монгол дарханы үйлдвэрлэлд импорт улаан тэмдэг асаачихаад байгаа нь энэ. Өдгөө үл анзаарагдам байж болох ч алсдаа зохицуулалт шаардахыг үгүйсгэхгүй. Цаашлаад урлагийн бүтээлд тооцдогдох энэ төрлийн бүтээгдэхүүнийг дэлхийн зах зээлд гаргах, монголоор овоглосон брэнд бий болгох боломж бий гэдгийг ч салбарынхан нуусангүй.

Үүнээс гадна алт, зэс, мөнгөөр баян хэмээн цээжээ дэлддэг манай улсын үйлдвэрлэлийн түүхий эд өнөөг хүртэл хар зах зээлээс хараат байна. Өөрөөр хэлбэл, энэ төрлийн бүтээгдэхүүний түүхий эд өнөөг хүртэл бүрэн баталгаатай биш. Энэ салбарт зориулсан бирж өмнө нь байсан ч одоо алга болжээ. Өдгөө хуучин бүтээгдэхүүнийг эргэн хайлуулж, шинээр хийх зэргээр үйлдвэрлэдэг гэнэ. Одоогоор дотоодын жижиг зах зээлийг хуучин түүхий эдээр торгоож байгаа ч олон улсын хэмжээнд бүтээгдэхүүн үйлдвэрлэж, брэнд болгохоор бол баталгаат түүхий эд баялгаар баян Монгол Улсад асуултын тэмдэг болох нь.

Хэдийгээр энэ зах зээлд шийдлээ хүлээж буй зарим зүйл байгаа ч нүүдэлчин монголчуудын уламжлал ул бололгүй эргэн ирж, сэргэн мандав. Ирэх ирэхдээ бүр илүү чанаржин, хийц, хэлбэр нь сайжран, нийтийн хэрэглээ болж буй нь сайшаалтай. [ЗГМ]

Зах зээлийн эрэлт эргэн сэргэснээс зөвхөн энэ төрлийн эдлэл хэрэглэл бүтээдэг уран дархан, борлуулдаг дэлгүүр, худалдааны төв цөөнгүй.

С.Батсайхан / ЗГМ©

“Улаанбаатар Элит”-ийнхэн монгол хэл, соёлоор бахархаж байна

“Улаанбаатар Элит” олон улсын дунд сургууль Монголын үндэсний хамгийн том уламжлалт баяр болох Цагаан сарыг тохиолдуулан “Монгол хэл, соёлын долоо хоног” арга хэмжээг зохион байгуулж байна. Сургуулийн үүдний хэсэгт жижигхэн гэр барьж, монгол гэрийн эд зүйлсийг багтаан тохижуулсан бөгөөд Сар шиний идээ будааг засаж зэхсэн нь “Улаанбаатар Элит” сургуульд ажилладаг 10 орны багш, 17 орны сурагчид төдийгүй монгол хүүхдүүдийн ч сонирхлыг ихэд татаж байв. Монгол гадаад, багш сурагч гэлтгүй бүгд энэ өдрүүдэд монгол үндэсний дээл хувцсаар гоёж, түүх соёлоор бахархаж байна.

Монгол хэл, соёлын долоо хоногийн хүрээнд мягмар гарагт 1-5 дугаар ангийн хөвгүүд(3 насны ангиллаар) үндэсний бөхөө барилдаж, хүч чадлаа үзсэн бол 6-12 дугаар ангийн сурагчид сур харваж, цэц мэргэнээ сорилоо. Мөн бага ангийн сурагчдын дунд “Монгол гоёл” загварын шоу болсон юм. Үндэсний сурын харвааны тэмцээнд оролцсон, 8-р ангийн сурагч Б.Жамбалцанжод “Сургуулиас сур харвах тэмцээн зохиож байгаа нь маш гоё санагдлаа. Багш нар маань хойч үед монгол ёс уламжлалыг өвлүүлж үлдээхэд тусалж байна. Энэ долоо хоногт би шагай нясалж сурсан. Бас зөв золгох ёсыг мэдэж авсан” хэмээн ярьсан бол Үндэсний бөхийн барилдаанд 4, 5 дугаар ангийнхнаа түрүүлсэн, 5 дугаар ангийн сурагч Ж.Талат “Дөрвөн бөхийг давж, түрүүлсэндээ их баярлаж байна. Эхний хоёр хүүхдийг давахад их догдолсон. Би анх удаа барилдаж байна. Зодог, шуудаг бас анх удаа өмсөж үзлээ. Их хүч чадалтай болсон юм шиг мэдрэмж төрсөн. Монгол хэлний хичээлээрээ бэлгэ дэмбэрэлийн үгсийн талаар үзээд, маш их зүйл мэдэж авсан. Өндөр настнуудын хэлсэн ерөөлийн үг үр хүүхдэд нь сайн сайхныг бий болгодог гэж ойлгосон” хэмээн ярьсан юм.

“Миний Монгол” гар зургийн уралдаан, “Бид сайхан бичигтэн” тэмцээнийг сурагчдын дунд мөн явуулж, шалгарсан бүтээлүүдийг үзэсгэлэн болгон гаргажээ. “Манай сургуульд гадны олон орны сурагч өөрийн орны хэл соёлыг хамгийн сайн аргаар суралцдаг. Энэ ч утгаараа бид Цагаан сарын баярыг тохиолдуулан Монгол хэл, соёлын долоо хоногийг тэмдэглэж байна. Хамгийн гол нь энэ бүхнээс хүүхдүүдийн сурч, мэдэж авч үлдэж байгаа зүйл их чухал юм. Энэ үйл ажиллагаанд маань сурагчид төдийгүй эцэг, эхчүүд маш идэвхтэй оролцож буйгаас гадна хүүхдүүд монгол хэл, соёлыг маш таатай байдлаар сурч, эзэмшиж байна” хэмээн “Улаанбаатар Элит” олон улсын дунд сургуулийн захирал Мехмет Элчи онцоллоо.

Энэ талаар 7а ангийн сурагч Ж.Аржан “Монгол хэл, соёлын долоо хоногийг зохион байгуулж байгаа багш нартаа үнэхээр баярлаж байна. Монгол бичиг миний дуртай хичээлүүдийн нэг бөгөөд монгол соёлыг тэтгэж байгаа гол зүйл нь гэж боддог. Дээл өмсөхөд надад яг монгол хүн болсон юм шиг мэдрэмж төрсөн. Хэвийн боовоор таваг засахдаа жаргал, зовлон, жаргал гэсэн дараалаар өрдгийг сая мэдэж авлаа. Бүх арга хэмжээ их сонирхолтой байна. Удахгүй монгол соёлын талаарх мэдлэгийн тэмцээн болно. Тэндээс илүү их юм мэдэж авах байх” хэмээн ярилаа.

Монгол хэл, соёлын долоо хоног эх хэлээрээ уран яруу, зөв сайхан ярихын чухал болон ёс заншил, түүх соёл, үнэт зүйлсээрээ бахархах, эх оронч үзлийг төлөвшүүлэх гээд олон талын ач холбогдолтой болж буйг сурагчдын ярианаас харж болно.

Сурагчид даваа гараг бүр Монголын Төрийн дууллыг дуулж, хичээлийн шинэ долоо хоногоо эхлүүлдэг. Энэ нь ч мөн “Улаанбаатар Элит” сургуулийн монгол хэл, соёлыг бэхжүүлэхэд оруулж буй том хувь нэмэр гэдгийг онцлох байна. Өнөөдөр “Монгол өв соёл” мэдлэгийн тэмцээн болон ахлах ангийнхны дунд болох “Монгол гоёл” загварын шоу болсноор Монгол, хэл солын долоо хоног өндөрлөнө.

ZGM DAILY

Government plans to plug budget deficit with ADB financing

Marketintel assess the solution may add public dissatisfaction towards the ruling party.

Thermal Power Plant 4's sales revenue reaches MNT 233.2 billion

The company issues a total of 36 tenders in 2017.

February Monthly Meeting of AmCham covers heavy industry

AmCham establishes a committee to build and implement policies and suggestions.

MSE ALL Index increases by 1.94 percent, to 1,186.26 points

Market cap stands at MNT 2,59 trillion.

ZGM: HIGHLIGHTS

POLITICS

On the occasion of the 50th anniversary of Mongolia's first Olympic medal, Parliament Speaker Enkhbold Miyegmobo receives Mongolian Olympic medal holders.

Jambaldorj Tserendorj, Ambassador Extraordinary and Plenipotentiary from Mongolia to the Republic of Albania, presents his letter of credence to Ilir Meta, President of Albania.

Cabinet passes a bill on military mobilization to be discussed during the Parliament's spring session.

ECONOMY

Ulaanbaatar City Administration seeks cooperation on its Bike Rental Service project.

According to the Development Bank of Mongolia, the bank has granted about MNT 1 trillion to over 1600 projects and programs through commercial banks up until now. Particularly, over MNT 700 billion investment was made to 50 projects and activities in the energy sector.

MSE ALL Index increases by 1.94 percent, to 1,186.26 points. Market cap stands at MNT 2,59 trillion.

SOCIETY

Mongolian Football Federation signs a memorandum of collaboration with the Qatar Football Association in Doha, Qatar.

Ministry of Health plans to reintroduce healthcare as an independent subject in the high school curriculum starting in the academic year of 2018-2019.

UNESCO registers Stone Stele monument of 'Mongolian Tanjur', which is currently preserved in the National Library of Mongolia, as a World documentary heritage.

Marketintel: Plugging budget deficit with ADB financing is inefficient

Ganbayar.B / ZGM©

Solutions to budget deficit may draw criticism

Tugsbilig.B
@tugsbiligZGM

In 2017-2018, the ADB allocated USD 468 million in funding to Mongolia, of which USD 130 million will now be used to plug the budget deficit for 2018. According to Marketintel, the loans are going to be spent on supporting access to quality education, developing regional roads in Mongolia, increasing renewable energy, improving transparency and efficiency of budget administration, and improving air quality in the capital city in accordance with the country partnership strategy of the ADB.

Mongolia, as a developing member country, is eligible for concessional market based ordinary capital resources lending (OCR) and regular market-based OCR lending from the ADB. The ADB has made USD 951 million of funding available for commitments during 2018–2020 for Mongolia's sovereign operations. This comprises of USD 144 million for concessional OCR and USD 807 million for regular OCR lending.

Last year, Mongolia successfully doubled down the state budget deficit to MNT 1.7 trillion. Taxation income increased by 27.3 percent that year, amounting to MNT 6.3 trillion. State revenue from income tax, value added tax and social insurance contributions were significantly improved in 2017. Lastly, state revenue from excise taxes noticeably decreased although the rates were moved up.

In order to improve public finance and revive economic development in 2018, the GoM has planned to take a number of measures such as:

• Reduce the budget deficit further by diversifying state revenue sources and effective public debt management
• Improve conditions of financial markets and involve more foreign and local participants
• Enhance accessibility to cheap finance through improved financial markets
• Decrease public debts by imposing limitations on sovereign bond issues
• Improve international investor sentiment and start stalled mega projects
• Improve fiscal discipline
• Introduce favorable taxation policies for businesses
• Produce fair and simple tax regime
• The solution is unlikely to receive public support

MarketIntel predict that plugging the state budget with ADB funding may attract some criticism from the public, political commentators and opposition parties. Even though there have been times where foreign aid was used to cover state budget deficits, it has now become an increasingly unpopular move for any governing party.

The solution to the state budget deficit may add further public dissatisfaction towards the ruling party and its government caused by previous political decisions such as the personal income tax hike and investigation progress on corruption scandals of high profile MPP members.

A recent poll conducted by MEC, a self-proclaimed independent research agency in Mongolia, suggests that the public is gradually losing faith in political parties in Mongolia and now prefers a presidential democracy over a parliamentary democracy. [ZGM]

ENERGY

Thermal Power Plant 4 increases profit by 7.6 percent

Thermal Power Plant 4 has released 2017 financial report, which indicated a net profit of MNT 273 million. The company was facing a profit loss due to foreign exchange rates in 2017. The report states that the sales revenue increased by 7.6 percent compared to the previous year and reached MNT 233.2 billion. The officials informed that the company overachieved the energy supply goal by 180 million kW per hour and fully complied with the heat supply plan.

The company focused on improving financial discipline and governance by cutting admissible expenses and increasing the number of open tenders. Aside from equipment tenders, the company issued a total of 36 tenders, such as bids for food and detergents.

Thermal Power Plant 4 provides electricity and heat to over 70 percent of the central region of the country. According to some sources, the company purchases around 50 percent of its coal supply from Shivee Ovoo mine. [ZGM]

FX MARKET

USD/MNT rate
(One month to date)



CNY/MNT rate
(One months to date)



RUB/MNT rate
(One months to date)



MINING

AmCham establishes Mining, Heavy Industry and Infrastructure Committee

Tugs.B
ZGM

The American Chamber of Commerce (AmCham) in Mongolia hosted its February Monthly Meeting with Sumiyabazar Dolgorsuren, Minister of Mining and Heavy Industry, Director of Mineral Resources and Petroleum Agency and other government officials yesterday.

Minister of Mining attends AmCham meeting

At the meeting, the participants exchanged views on issues affecting the development of the mining and heavy industries, and Minister Sumiyabazar provided updates on key legal reforms and plans for mining and heavy industry that will have the potential to bolster private sector development and promote foreign investment.

In his keynote address, Minister Sumiyabazar expressed his gratitude towards AmCham Mongolia's efforts in supporting and strengthening the private sector. He noted, "Today's Monthly Meeting organized by AmCham is coming at a very timely moment. I, as the minister, representing the Government of Mongolia, am very much adhering to a principle of undertaking a stable and open policy for investors who have demonstrated great commitment and responsibility. In my opinion, policies and actions happening within this sector should definitely be grounded on key principles, such as human development and the environment, which is imperative for the country's development. In addition to being transparent, mining activities should be carried out with a high degree of responsibility, and the Ministry of Mining and Heavy Industry is constantly striving to reflect these principles in its policy documents and decisions.

The Ministry of Mining and Heavy Industry will be ready to collaborate with AmCham's newly established Mining, Heavy Industry and Infrastructure Committee in order to build and implement policies and suggestions aimed at providing tangible support to responsible domestic and foreign investors."

After wishing success for the ministry in its upcoming participation in the Prospectors & Developers Association of Canada convention, Mr. Steve Potter, Chairman of AmCham Mongolia, stated, "The Minister's attempts to update major policy documents relevant to mining production and heavy industry, including the elaboration of new Mining Law, is not only crucial to solving legal overlaps but also vital to reviving investor confidence and attracting more foreign investment. In order to support Mongolia's efforts to develop these leading sectors and to protect the rights and interests of the private sector, AmCham is establishing a new Mining, Heavy Industry and Infrastructure Committee, to develop a responsible and competitive mining sector capable of creating a solid and reliable foundation for economic growth and the country's development.

AmCham Mongolia strongly believes in effective collaboration between the Ministry of Mining and Heavy Industry and AmCham by aligning itself with the government's priorities and programs, as well as with the interests of our members." [ZGM]

НЭЭЛТТЭЙ ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТ

Огноо: 2018.02.12

Тендерийн нэр, дугаар: МИАТ ТӨХК-ийн Агаарын хөлгийн иж бүрэн даатгалын тендер MIAT/201801138 Хялбаршуулсан цахим тендер

Гэрээний нэр: МИАТ ТӨХК-ийн Агаарын хөлгийн иж бүрэн даатгалын гэрээ

"МИАТ" ТӨХК нь эрх бүхий тендерт оролцогчдыг "МИАТ" ТӨХК-ийн Агаарын хөлгийн иж бүрэн даатгалын үйлчилгээ үзүүлэх тухай тендер ирүүлэхийг урьж байна.

Тендерийн баримт бичгийн үнэ 50,000 (тавин мянга) төгрөг байна.

Тендер нь түүнийг нээсэн өдрөөс хойш 45 хоногийн хугацаанд хүчинтэй байх ба 86 000 000 / наян зургаан сая/ төгрөгтэй тэнцэх төгрөгийн, эсхүл үнэтэй дүйцэхүйц дүн бүхий чөлөөтэй хөрвөх валют бүхий тендерийн баталгаатай хамт ирүүлнэ.

Тендерийг 2018.03.15 өдрийн 09:00 цагаас өмнө ирүүлэх бөгөөд тендерийг 2018.03.15 өдрийн 09:30 цагт нээнэ.

Гадаадын хуулийн этгээд тендерт оролцох эрхтэй.

ХАЯГ: Хан-Уул дүүрэг, 10-р хороо, Буянт- Ухаа, "МИАТ" ТӨХК-ийн төв байр, Харилцах утас 7004-9860, 99992742 Факс 976-11-7004-9919

Өдрийн хэмнэл

ТВ ХӨТӨЛБӨР

MNB

09:00	“Шерлок Холмс” УСК
11:00	“Монголын мэдээ” мэдээллийн хөтөлбөр
14:00	“Тод магнай” МУСК
17:45	“Маамуу” хүүхдийн нэвтрүүлэг
19:30	Утга уянгын хэлхээс
21:10	“Манай бэр” реалити шоу

Bloomberg TV Mongolia

08:00	"Bloomberg Daybreak Asia" нэвтрүүлэг
11:30	"Ажил хэрэгч өглөө" нэвтрүүлэг
14:30	"Ногоон хот" нэвтрүүлэг
17:00	"Bloomberg Surveillance"
20:30	"Бизнес аялал" нэвтрүүлэг
22:30	"Хариуцлага ба үнэ цэнэ" нэвтрүүлэг

БОЛОВСРОЛ HD

09:00	"Урагшаа Торара урагшаа" хүүхэлдэйн кино
11:35	Үүнийг хэрхэн хийдэг вэ?
14:05	"Хүрээлэн" амьд ертөнц нэвтрүүлэг
18:05	"Бяцхан оцон шувуу Пороро"
19:00	"Царай муутын мөн чанар" ОАК
21:00	"80 саяын уналт" асуулт хариултын шоу нэвтрүүлэг

МОНГОЛ TV

09:30	"Тог тог тог" хөтөлбөр
11:40	"Үлгэрийн цаг" 13 дугаар хэсэг
15:30	"Миний дүрсгүй гүнж" СОАК
17:30	"Жимсхэн охид" хүүхэлдэйн кино
19:30	"Мөрдөгч хүүхдүүд" ОАК
21:00	"Хуурай эгч дүүс" СОАК

ЗУРХАЙ



Билгийн тооллын 29
Өвлийн адаг харагчин үхэр сарын зургаан цагаан мэнгэтэй, улаагчин үхэр өдөр.
Үс засуулбал: Сүлд тэнэж одно
Наран ургах, шингэх: 07.50-18.15
Барилдлага: Идэр
Шүтэн барилдлага: Сансар

Аргын тооллын хоёрдугаар сарын 14, Буд гараг. Билгийн тооллын 29. Яруу эгшигт одтой, улаагчин үхэр өдөр.
Өдрийн наран 07.50 цагт мандаж, 18.15 цагт жаргана. Тухайн өдөр тахиа жилтнээ аливаа үйл хийхэд эерэг сайн ба могой, морь жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр эе, эвээ ололцох, хамтын хөдөлмөр эхлэх, гэрээ хэлцэл байгуулах, найр хурим хийх, бэр гуйх, инж өгөх, авах, үнэт эрдэнийн зүйл авах, угаал үйлдэх, мал арилжих, гэр бүрэхэд сайн. Улааны үйлд муу. Өдрийн сайн цаг нь бар, туулай, могой, бич, нохой, гахай болой. Хол газар яваар одогсод баруун хойш мөрөө гаргавал зохистой. Модон хохимой өдөр. Үс шинээр үргээлгэх буюу засуулахад тохиромжгүй.

”Бүжгээр урлахуй” гала тоглолт
Хэзээ: 2018.02.10-нд 17.00 цагт.
Хаана: Дуурь бүжгийн эрдмийн театр
Тасалбарын үнэ: ₮ 10-20 мянга

”Би ч гэсэн жаргамаар байна”
Хэзээ: 2018.02.14-нд 18.00 цагт.
Хаана: УДЭТ
Тасалбарын үнэ: ₮ 10-25 мянга

”Хайртай хүндээ” тоглолт
Хэзээ: 2018.02.14-нд 19.00 цагт
Хаана: Shangri-La centre
Тасалбарын үнэ: Үнэ төлбөргүй

ОНЦЛОХ ҮЗВЭР

Ширэнгэд тавтай морил

Одоогоос 23 жилийн өмнө эгч дүү хоёр эртний учир битүүлэг тоглоом олсноор тэдний амьдралд санаанд оромгүй хачин зүйлс тохиолддог. Тэгвэл хачин жигтэй амьтад, бидний төсөөлөө ч үгүй ширэнгэн ойн амьдрал дахин үргэлжилсээр.

Ахлах сургуулийн дөрвөн сурагч сахилгын шийтгэл авч, агуулах цэвэрлэх үүрэг хүлээдэг. Тэд агуулахыг нэгжиж байгаад гар удирдлагатай хуучин тоглоом олж, тоглох болно. Гэвч сурагчид тоглоомынхоо сонгосон дүрд буюу насанд хүрсэн хүмүүс болж ширэнгэн ойд очдог. Тэрхүү ширэнгэн ой ер бусын газар тул тэд аюул, занал, аврал, амь өрссөн тэмцэл гээд санаанд оромгүй зүйлстэй нүүр тулах болно.

“Sony pictures”-ийн бүтээл “Ширэнгэд тавтай морил” буюу Жуманжи киноны хоёрдугаар анги 90 сая ам.доллараар бүтэж, өнгөрсөн оны арванхоёрдугаар сарын 22-нд нээлтээ хийсэн билээ. Киноны найруулагчаар Жейк Касдан ажиллаж, гол дүрүүдэд Двейн Жонсон, Кевин Харт, Жейк Блэк нар тогложээ. Энэ кино гарсан долоо хоногтоо л “Box Office”-ийн жагсаалтыг тэргүүлж, Хойд Америкийн кино театруудаас нийт 27 сая ам.долларын ашиг олсон юм. Харин олон улсаас олсон нийт орлого нь 667 сая ам.доллараар хэмжигдэж байгаа аж. [ЗГМ]

”L.O.V.E” тоглолт
Хэзээ: 2018.02.14-нд 20.30 цагт.
Хаана: English Inn
Тасалбарын үнэ: ₮ 20 мянга



”Forever” тоглолт
Хэзээ: 2018.02.14-нд 19.00 цагт.
Хаана: Crocus Event Hall
Тасалбарын үнэ: ₮ 35 мянга

“I love you” тоглолт
Хэзээ: 2018.02.14-нд 19.00 цагт.
Хаана: Улсын филармони
Тасалбарын үнэ: ₮ 25 мянга

ЗГМ: ҮГИЙН СҮЛЖЭЭ



БОСООГООР:
1. Өвлийн олимпийн анхдугаар наадам зохиогдсон хот (Франц)
2. Хан-Уул дүүргийн нэгэн хороолол
3. Улс төрийн нам (товчилсон нэр)
4. 1931 онд үүсэн бий болсон үйлчилгээний томоохон салбар (товчилсон нэр)
5. Төв Африк дахь нэгэн улс
6. Дэлхийн хамгийн үнэтэй хөлбөмбөгчин
9. Улаанбаатар хот дахь Мобикомийн төв үйлчилгээний байр
10. Баян-Өлгий, Увс аймгийн заагт орших тусгай хамгаалалт бүхий нуур
11. Өвлийн олимпийн VI наадмыг хүлээн авсан Норвегийн хот

ХӨНДЛӨНГӨӨР:
1. Цагаан сарын (мөн бусад сарын) эхний өдөр
7. Өвлийн спортын зарим төрлийн өрсөлдөөний талбар
8. Дээдсийн харшууд орших Богд уулын нэгэн ам
11. Байгууллагын мэдээллийн алба (товчилсон нэр)
12. Обь мөрний хамгийн том цутгал гол
13. Өвлийн спортын нэгэн сонирхолтой төрөл

Өмнөх дугаарын хариу / 2.13

ЗГМ: СУДОКУ

					1		9	
2	7				4	5		
	5		8			6		
	3			2	9		1	
9								5
	1		7	4			6	
		1			5		7	
		6	4				3	8
	8		1					

6	2	9	5	3	1	7	4	8
4	8	5	9	6	7	1	3	2
1	7	3	2	4	8	9	5	6
5	3	2	1	7	6	8	9	4
7	9	4	8	2	5	6	1	3
8	1	6	4	9	3	2	7	5
3	5	7	6	1	2	4	8	9
9	6	8	7	5	4	3	2	1
2	4	1	3	8	9	5	6	7

(Өмнөх дугаарын хариу)

ЦАГ АГААР

УЛААНБААТАР

II.14	II.15	II.16	II.17	II.18
-12° / -23°	-12° / -21°	-10° / -21°	-9° / -20°	-12° / -20°
6 м/с / 5 м/с	6 м/с / 6 м/с	7 м/с / 5 м/с	7 м/с / 6 м/с	7 м/с / 5 м/с
Багавтар үүлтэй	Үүлшинэ	Үүлшинэ	Үүл багасна	Бага зэргийн цастай



ЗГМ: КОМИК



ГАЛТ ТЭРЭГНИЙ ЦАГИЙН ХУВААРЬ

ЭРХҮҮ-УБ	15.35	06.20
УБ-ЭРХҮҮ	21.10	02.40
УБ-СҮХБААТАР	10.55	19.52
СҮХБААТАР-УБ	06.30	15.35
УБ-ЭРДЭНЭТ	20.30	07.45
ЭРДЭНЭТ-УБ	19.10	05.48
УБ-ЗАМЫН-ҮҮД	17.20	07.20
ЗАМЫН-ҮҮД-УБ	17.35	08.55
УБ-ЗҮҮНХАРАА	17.30	21.45
ЗҮҮНХАРАА-УБ	04.25	08.40
УБ-САЙНШАНД	09.15	19.15
САЙНШАНД-УБ	20.25	07.01

НИСЛЭГИЙН ЦАГИЙН ХУВААРЬ

УБ-ХАНБУМБАТ	07.00	08.10
ХАНБУМБАТ-УБ	09.00	10.05
УБ-СӨҮЛ	07.45	12.05
СӨҮЛ-УБ	13.20	16.05
УБ-БЭЭЖИН	17.15	19.30
БЭЭЖИН-УБ	20.30	23.00
УБ-ХОНКОНГ	08.55	14.30
ХОНКОНГ-УБ	15.30	20.25
УБ-БАНКОК	17.30	22.50
БАНКОК-УБ	23.50	07.00 +1

Syndicated articles from

FINANCIAL TIMES

© The Financial Times Limited [2015]. All Rights Reserved. Not to be redistributed, copied or modified in anyway. ZGM is solely responsible for providing these translated articles and the Financial Times Limited does not accept any liability for the accuracy or quality of the translation.

MBA-д сурахад эцэг эхийн дэмжлэг нөлөөлдөг

Грейс Бейкер хоёр хүүдээ элсэлтийн шалгалтын зөвлөгөө авахад 14000 ам.доллар зарцуулжээ. > 10

Европын холбооны цэргийн бодлого АНУ-ыг түгшээв

Европын холбооны гишүүн орнууд батлан хамгаалах харилцаагаа зузаатгахаар төлөвлөж байгаа нь НАТО-д цохилт болж магадгүй. > 10

Оросын засаглалын системийг тайлбарлахад бэрх

XIX-XX зууны туршид Герман улс үнэлэмж, үүрэг зорилтоо ойлгохын төлөө тэмцэж, тогтвортой байдлыг бусниулж байв. > 10

Авлигын эсрэг хууль яллагдагчийг ямар ч хамгаалалтгүй болгоно

Люси Хорнби

Авлигын эсрэг хуулийн шинэ төсөл нь яллагдагчийг шүүхээс хамгаалах зорилготой 20 жил үргэлжилж буй эрх зүйн шинэчлэлийг халах аюултайг эрдэмтэд анхааруулж эхэллээ.

Ши Жиньпиний авлигатай тэмцэх аяны нэг хэрэглүүр, ХКН-ын байцаагчдын гүйцэтгэдэг "шуангуй" хэмээх хуулиас гадуурх баривчилгаа нь намын жирийн гишүүдэд танил бус. Ийм ч учраас БНХАУ-ын дарга үүнийг хуулийн дагуу баривчлах тогтолцоогоор солихоор амласан юм.

Үндсэн хуульд оруулахаар энэ сард санаачилсан өөрчлөлтөд намын эрх мэдлийг төрийн бүх байгууллагад өргөжүүлэх Улсын хяналтын комисс байгуулахаар заажээ. Комиссын эрх мэдэл нь төрийн байгууллагын ажилтан намын гишүүн юм уу гишүүн бус байхаас үл хамааран бүгдэд үйлчилнэ. Мөн Хятадын иргэний хуульд заасан аливаа хамгаалалт комиссын шалгалтад үйлчлэхгүй.

Шинэ хууль хэрэгжвэл авлига авсан төрийн ажилтан хүний амь хороосон алуурчнаас ч бага хамгаалалттай болно.

Уг өөрчлөлт Хятадын шүүхийг мэргэжлийн болгох, сэжигтнүүдэд хуулиар хамгаалуулах эрх олгох зорилготой олон жилийн хүчин чармайлтын эерэг "том ухралт" хэмээн Нью Йоркийн их сургуулийн Хятадын шүүхийн эксперт Жером Коэн тайлбарлав. Яллагдагч өмгөөлөгчтэйгээ уулзах, байцаалтын үеэр тамлуулахгүй байх ч энэхүү хүчин чармайлтад багтаж байлаа.

"Улстөрч, төрийн ажилтан, бизнесийн удирдлага, тэдний ажилтнууд, прокурор, шүүгч, хууль тогтоогч, профессор, ялангуяа хуульчид илт дарангуй тогтолцооны дараагийн золиос болох аюултай"-г ноён Коэн өгүүлсэн юм. Мөн "Хятад хэлбэртэй испани бурангуй шашны" хэмээн тэрбээр тодорхойлж байлаа.

Шинэ хууль нь намын эрх мэдлийг цэцэрлэгийн багш, шуудан түгээгч, эмч нар болон удирдах дээд албаны хүмүүс, төрийн өмчийн компанид ажиллагсад, төрийн бүх ажилтанд хамаатай болгов. Үүний улмаас "люжи" буюу намын нууц мөрдөн шалгах тогтолцоо, дураараа баривчлах журмаар нам бус олон арван сая хүмүүсийг хамарна. Улсын хяналтын комисс нь "төр, намын хяналтыг нэгтгэж буй хэрэг" хэмээн Хятадын улс төрийн ухаан, хуулийн их сургуулийн дэд ерөнхийлөгч Ма Хуайдө жилийн өмнө тайлбарлаж байв. Эрүүгийн хуулиар олгодог хамгаалалт шинээр хуульчлах баривчилгааны үед үйлчлэхгүй гэдгийг ноён Ма нэмж дурдсан. Тэрбээр илүү нарийн тайлбар хэлэхээс татгалзлаа. Шинэ өөрчлөлт авлигатай тэмцэх ажиллагааг "илүү цэгцтэй болгож болзошгүй"-г Калифорнийн их сургуулийн Берклийн хуулийн сургуулийн Хятадын эксперт Стэнли Любмэн өгүүллээ. "Намын манлайллыг чухалчилж буй энэ өөрчлөлт шүүх засаглалыг намд захирагдах ёстойн дохио" хэмээн тэрбээр үзэж байна.

Human Rights Watch-оос ноцтой тайлан гаргасны дараа, намын мөрдөн шалгалтаар тамлан зовоох явдал гарахаас сэргийлэхийн тулд видео бичлэг хийж байхыг Хятадын авлигатай тэмцэх байгууллагын тэргүүн байсан Ван Чишань 2016 оны эцсээр уриалжээ. Эрүүгийн нийтлэг гэмт хэрэгт тамлан зовоох аргаар гэмийг нь хүлээлгэхийг Хятадад 2010 оноос хойш хууль бус хэмээн тооцдог болсон.

Намын эрх мэдлийг төрийн байгууллагад үйлчлэхээр өргөжүүлсэн нь 1970-аад оны эцсээс эхлэн Хятадад мэргэшсэн иргэний засаглал бий болгохоор өрнөсөн шинэчлэлээсээ ухарсан хэрэг боллоо.

Өнгөрсөн аравдугаар сард хуралдсан ХКН-ын Их хуралд яамдын намын хорооны нарийн бичгийн дарга нар чухал үүрэг гүйцэтгэсэн нь энэхүү ухралтын тод илрэл байлаа. Өмнө нь яамдыг ихэвчлэн сайд нар нь төлөөлдөг байсан юм.

FT

Дайсагнал ихэссэн нь шинэ мөргөлдөөний дохио боллоо

Дэвид Гарднер

Израилын байлдааны онгоцыг Сирийн агаараас хамгаалах хүчин буудаж унагалаа. Уг хэргийн дараа Сирийн нутгаас хөөрч Израилийн агаарын орон зайд нэвтэрсэн Ираны дроныг устгаснаа Иерусалим мэдэгдлээ. Эдгээр хэрэг нь Сирийн иргэний дайны дараа бүс нутагт шинээр дайн дэгдэх аюул нүүрлэж буйг харуулж байна.

Израиль, Иран болон тэдний холбоотнуудын хооронд шинэ дайн яг одоо биш ч тун удахгүй дэгдэх бүх нөхцөл бүрдээд байна. Ойрх дорнодын тэнгэрт ноёлж ирсэн Израилийн агаарын цэргийн хүчин хөршийнхөө иргэний дайны оргил үеэр Ливаныг эзлэн түрэмгийлсэн 1982 оноос хойш онгоцоо алдсан удаагүй. Израиль энэ долоо хоногт Сирийн нутгийн гүнд 10 гаруй удаа агаараас цолилт өгсний дөрөв нь Ираны байг оножээ.

Анх 2011 онд Арабын хаврын давалгаагаар бослого хөдөлгөөн эхэлсэн Сирийн иргэний дайн даамжирсаар Турк, Иран, АНУ, ОХУ зэрэг бүс нутгийн болон дэлхийн тоглогчдыг хамарсан юм. Иран, түүний холбоотон Ливаны Хезболла хүчирхэг зэвсэгт бүлэглэл 2015 оноос хойш ОХУ-ын агаарын хүчний дэмжлэгтэйгээр Башар Асадын үндэсний цөөнхийн дэглэмийг суннит босогчдын дайралтаас хамгаалж байна.

Долоон жилийн эцэст Ерөнхийлөгч Асад ОХУ, Иранын хамгаалалт дор бүр ч эрх мэдэлтэй болж авав. Өрнөд Сирийн агаарын орон зайг үндсэндээ оросууд хянаж байна. Иран нь өөрийн Исламын хувьсгалт гвард, Хезболла, Ирак, Афганы шийт босогчдоор дамжуулан бүс нутагт бэхжсээр буй. Тегеран тус бүс нутагт шийт арабуудыг нэгтгэж, Загросын уулсаас Газар дундын тэнгис хүртэл гарц үүсгэхээр эрмэлздэг. Ираны санаархлыг Израиль стратегийн үүднээс хүлээн зөвшөөрөх аргагүй зүйл хэмээж байна.

Хезболлатай 30 гаруй жил дайтаж буй Израиль анх Сирийн дайнд шууд хутгалдахаас зайлсхийсэн. Гэвч 2013 оноос тус улс Хезболлад нийлүүлэх Ираны зэвсэг техникийн хангамжийг тасалдуулах, саяхнаас Ираны баазуудыг хараалахаар Сирид 100 гаруй удаа агаараас цохилт өгсөн юм. Иран, Хезболлагийн цэргийн оролцоо Сирид байнгын болж хувирвал Ливаны хилийн дагуу Израилын эсрэг фронтын шинэ шугам үүснэ. Хезболла 2006 онд бүс нутагт бэхжихээр таван долоо хоног дайтсанаас хойш Ливаны босогчид Иранаас нийлүүлсэн, Израилийн гүнд тусах чадвартай пуужингийн үлэмж нөөц хуримтлуулжээ. Энэхүү пуужингийн нөөц, пуужингийн үйлдвэрийг Ливаны нутгаас илрүүлсэн нь Израилийн тэвчээрийг барагдууллаа. Израилийн хилийн ойролцоо үүсээд буй нөхцөл нь Сири, магадгүй Ливаныг Израиль, Ираны хоорондох дайны талбар болгон хувиргах аюул нүүрлэв.

Ийм дайн дэгдэх нь Сирийн тэнгэр, булаацалдаж буй газар нутагт эдүгээ өрнөж буйгаас илүү сүйрлийн уршигтай. Израилийн нисэх онгоцыг унагасан хэргээс гадна, Идлиб мужид Оросын онгоцыг жихад нар унагаж, Сирийн баруун умардад курд дайчид Туркийн нисдэг тэргийг устгасан. Энэ бүхэн ердөө өнгөрсөн долоо хоногт болж өнгөрсөн юм. Мөн л өнгөрсөн долоо хоногт Евфратын хөндий дэх Асадыг дэмжигч хүчийг АНУ агаараас арчиж хаялаа. Афганы шийт болон араб дайчдаас бүрдсэн уг хүч Вашингтоны курд холбоотнуудад заналхийлж байжээ.

FT

АНУ, Умардтай хэлэлцээ өрнүүлэхэд бэлэн

Брайан Харрис

Умард Солонгостой дипломат байр сууринаас харьцахаар Сөүл тохиролцсон. Үүний дараа АНУ Пхеньянтай шууд яриа хэлэлцээ өрнүүлэхэд бэлэн хэмээн дэд ерөнхийлөгч Майк Пенс мэдэгдлээ.

АНУ "та нар ярилцмаар байгаа бол бид бэлэн" гэсэн байр суурь баримталж буй. Гэхдээ ийм байр суурь нь Трампын засаг захиргаанаас бусад улсын туслалцаатайгаар Умард Солонгосын эдийн засгийн хоригийг суллах гэсэн хэрэг биш гэдгийг ноён Пенс Washington Post-д тайлбарлав.

Өвлийн олимпын үеэр дипломат ажиллагаа идэвхжиж, Умард Солонгосын дарангуйлагч Ким Жон Ун Өмнөд Солонгосын Ерөнхийлөгч Мун Жэ Инийг Пхеньянд айлчлахыг урьсан энэ үед ноён Пенсийн тайлбар гарч байна. Дэд ерөнхийлөгчийн тайлбарыг бодлого өөрчлөгдөж буйн илрэл хэмээн зарим нь үзлээ. Харин ноён Пенс Умард Солонгостой харьцах бодлого "өөрчлөгдөөгүй"-г онцлон сануулсан юм.

"Яриа хэлэлцээ боллоо ч, Умард Солонгос цөмийн хөтөлбөрөө орхихгүй л бол хатуу хориг арга хэмжээ, үнэмлэхүй дарамт шахалт улам чангарна. Үүнийг холбоотнууд маань ч дэмжиж байгаа" гэмээн Дэд ерөнхийлөгч Twitter-т бичжээ.

Washington Post-д өгсөн тайлбар нь хэлэлцэн тохирох гэвэл эхлээд Пхеньян цөмийн зэвсгээсээ татгалзах саналаа илэхийлэх ёстой хэмээн Дэд ерөнхийлөгч Өмнөд Солонгост урьд нь мэдэгдэж байснаас зөрж буй мэт. Гэхдээ Трампын засаг захиргаа хоёрдмол утгатай мэдэгдэл анх удаа гаргаж буй хэрэг биш.

АНУ-ын Төрийн нарийн бичгийн дарга Рекс Тиллерсон арванхоёрдугаар сард урьдчилсан болзолгүйгээр яриа хэлэлцээ өрнүүлж болох тайлбар хэлж байсан. Гэтэл ноён Тиллерсон даваа гарагт Каирт үг хэлэхдээ ноён Пенсийн мэдэгдлийг эс хайхрав.

"Яриа хэлэлцээ өрнүүлэх дипломат боломжийн талаарх Дэд ерөнхийлөгчийн тайлбар арай л эртэдсэн дүгнэлт болов уу" хэмээн ноён Тиллерсон өгүүллээ. "Ярилцахад бэлэн эсэхээ Умард Солонгос өөрөө шийднэ гэж бид урьд нь хэлж байсан" хэмээн Төрийн нарийн бичгийн дарга тайлбарлав. Гэхдээ Умард Солонгос асуудлыг шийдвэрлэхэд ноцтой хандаж буй эсэхийг тодорхойлох зорилготой зарим яриа АНУ-д болсныг тэрбээр нэмж өгүүлсэн юм.

Ярилцах хүсэлтэй ч Пхеньянтай тохиролцох нь ямар ч үр дүнгүй хэмээн ноён Трамп тайлбарлаж байсан удаатай. Хоёр Солонгосын дээд хэмжээний болзошгүй уулзалтын өмнө Солонгосын хойгийн хурцадмал байдлыг намжаах зорилготой зарим арга хэмжээг Сөүл даваа гарагт авлаа. Хоёр талын харилцааг гүнзгийрүүлэх, ялангуяа Солонгосын дайнаар салсан гэр бүл, ахмадуудыг эргүүлэн нэгтгэх арга хэмжээ авахыг Сөүл дэх Нэгтгэх яам уриалж байна. Үйл явдлын өрнөлөөс таамаглахад ноён Кимтэй уулзах уулзалтаасаа өмнө Умардаар буулт хийлгүүлэх ёстойгоо ноён Мун ухамсарлаж буй бололтой. .

"Дан ганц урилга үр дүнгүй өнгөрч болохыг Мун Жэ Ин ойлгож байгаа. Одоо Умард Солонгос арай урагштай алхам хийх ёстой" хэмээн Солонгосын хөгжлийн хүрээлэнгийн профессор Ким Бюн Жү тайлбарлав.

Солонгосын хойгт энх тайвныг бэхжүүлэхийг дэмждэг Өмнөд Солонгосын залуу үеийнхэн, АНУ-ын албаныхны дотор Пхеньяны байр суурь дэглэмийнхээ ашиг сонирхолд үйлчлэхээс цаашгүй гэсэн гутранги байр суурь зонхилж байна. Ноён Муны хувьд Умард Солонгосоор бодитой буулт хийлгүүлж чадна гэдгээ Сөүл дахь улс төрийн өрсөлдөгчид, Вашингтон дахь Өмнөд Солонгосын холбоотнуудаа үзүүлэх хариуцлага тулгарлаа.

"Ноён Муны тоглох зай тун бага. Бөмбөг одоо Ким Жон Уны талбайд шилжсэн" хэмээн профессор Ким өгүүлж байлаа.

FT

Syndicated articles from

FINANCIAL TIMES

© The Financial Times Limited [2015]. All Rights Reserved. Not to be redistributed, copied or modified in anyway. ZGM is solely responsible for providing these translated articles and the Financial Times Limited does not accept any liability for the accuracy or quality of the translation.

MBA-д сурахад эцэг эхийн дэмжлэг нөлөөлдөг

Жонатан Мюлз

Грейс Бейкер хүүхдүүдээ Харвард, Стэнфордын бизнесийн магистрын хөтөлбөр төгссөнд бахархдаг нэгэн. Гэвч жинхэнэ нэрээ нийтлүүлэхийг хүсээгүй энэ эмэгтэй хоёр хүүдээ элсэлтийн шалгалтын зөвлөгөө авахад 14 мянган ам.доллар зарцуулжээ. Тэрбээр "Энэ бол хөрөнгө оруулалт" гээд Манхэттэнд амьдардаг хөршүүд нь бүр илүү мөнгө гаргаж, хүүхдийнхээ магистрын сургалт, амьдрах зардлыг даасан гэж ярилаа. Хатагтай Бейкер гаднаас зөвлөгөө авсан нь хүүхдүүддээ зүг чигээ олоход туслах, амжилтад урамшуулах зорилготой байсныг өгүүлэв.

Бизнесийн сургуульд элсэгчдийн эцэг эхээсээ авдаг тусламж жил бүр нэмэдсээр байна. 2009 онд 15 хувь нь дэмжлэг авдаг байсан бол 2014 онд 22 хувь болж өсөв. GMAC байгууллагын судалгаагаар энэ тоо жаахан буурсан болович өнгөрсөн онд 18 хувьтай байв. Сургалтын зээлийн хэмжээ багасахтай зэрэгцэн эцэг эхийн дэмжлэг нэмэгдсэнийг судалгаанаас харж болно. Түүнчлэн мөн хугацаанд ажил олгогчдын санхүүгийн дэмжлэг 12 байснаас найман хувь болж буурчээ.

Европын оюутнууд ч мөн хол хоцорсонгүй арван магистрын гурав нь аав ээжээсээ мөнгө хүлээдэг аж. Азид ч ялгаагүй.



Бизнесийн хөтөлбөрийн санхүүжилт

Хятадын хойд нутгийн оюутан Фэйт Сугийн эцэг эх ганц охиноо Барселоны бизнес сургуульд суралцуулахын тулд байшингаа багасгаж, 88 мянган еврог сургалтын төлбөрт өгчээ. 27 настай Су сургуулиа төгсөөд технологийн салбарт амжилт гаргана гэж найдаж буй. Бээжинд их сургууль дүүргэсэн тэрбээр Мюнхений онлайн худалдааны старт-аппт ажилд орж, Хятад руу хүүхдийн бараа илгээдэг салбарынх нь орлогыг дээш татжээ. Энд ажиллаад бизнесийн удирдлагын туршлага суусан болович амьдралд хүрэлцэх мөнгө олж чадаагүй гэнэ. Магистрын хөтөлбөр Суд хэдийнэ ач тусаа өгч, Amazon-ы удирдлагын хөгжлийн хөтөлбөрт хамрагдаад байна. Индонезийн оюутан Нгура Линггихийн эцэг эх түүнийг Германы WHU бизнес сургуульд элсүүлэхэд 47 мянган евро төлжээ. Усны цэвэршүүлэх төхөөрөмжийн бизнес эрхэлж, усан бассейн ажиллуулдаг аав нь Иллинойсын их сургуулийн магистрыг дүүргэсэн хүн юм. Ноён Линггих "Тэр надад боловсрол амьдралд хэзээд хэрэг болно гэж хэлдэг байсан" хэмээн өгүүллээ. Тэрбээр гэр бүлийн бизнесээс дэмжлэг авсан болович технологийн старт-апп нээнэ хэмээн найдаж буй.

Америкийн бизнесийн сургуулиудын арван оюутны нэг нь эцэг эхээсээ санхүүгийн дэмжлэг авдаг гэж GMAC-ын судалгаанд дурджээ. Хорин жилийн өмнө Лос Анжелест MBA-д элсэх зөвлөгөө өгдөг фирм байгуулсан Стейси Блэкман хүүхдээ өөр шигээ амжилтад хүргэхийг хүссэн эцэг эхчүүд манайд ханддаг гэж ярьсан юм. Тэрбээр "Эцэг эхчүүд хүүхдэдээ хэлэлгүйгээр манайх руу утасдах нь олширсон. Зарим нь санаа зовсондоо тэгдэг байх. Гэвч олонх тохиолдолд хүүхэд нь ямар ч завгүй тул эцэг эхчүүд бидэнтэй эхлээд ярилцдаг" гэв. Сайн сургуульд орох өрсөлдөөн нэмэгдэж буй энэ үед олон эцэг эх хүүхдээ өөрсдийнхөө сурч байсан сургуульд элсэж чадахгүй байх хэмээн түгшдэг болжээ.

North Star элсэлтийн зөвлөгөөний фирмийн захирал Карен Маркс "Эцэг эхчүүд хүүхдээ өөр шиг нь амжилтад хүрээсэй гэж хүсдэг. Энэ бол үе залгамжлалын асуудал" хэмээв. Хатагтай Бейкерийн найзуудын нэрээ хэлэхийг хүсээгүй нэгэн эмэгтэй хөрөнгө оруулалтын компанид ажиллаж байсан хүүгээ MBA төгсгөхийн тулд зургаан оронтой тоогоор хэмжигдэх мөнгө төлжээ. Тэрбээр "Хүү маань санхүүд дургүй байсан. Иймээс хүүгээ төлбөртэйгөө дүйхүйц алдартай сургуульд сургахаар шийдсэн. Хэрэв эцэг эх нь найдвартай орлоготой бол хүүхэд өсгөх хамгийн том зардлын нэг бол бизнес ийн сургууль" хэмээн өгүүллээ.

FT

Европын холбооны цэргийн бодлого АНУ-ыг түгшээв

Катрина Мансон

Европын холбооны гишүүн орнууд батлан хамгаалах харилцаагаа зузаатгахаар төлөвлөж байна. Энэ нь Оросыг сөрөх ёстой НАТО-д цохилт болж магадгүй гэж АНУ түгшиж байна. НАТО-г хариуцсан Пентагоны ахлах ажилтан Кэти Вилбаргер "ЕХ-ны хүчин чармайлт НАТО-гийн цэргийн хүчийг татахыг хүсэхгүй байна" гэжээ. Тэрбээр ЕХ-ны дотоод хамтын ажиллагаа НАТО-гийн гишүүн орнуудын Афганистан, Иракт гүйцэтгэж буй үүргээс нь холдуулах ёсгүй хэмээв. АНУ-ын Батлан хамгаалахын сайд Жим Мэттис НАТО-гийн удирдлагатай Брюссельд уулзаж, цэргийн зардлаа нэмэхийг шаардахын өмнөхөн хатагтай Валбаргер иим мэдэгдэл хийлээ. АНУ үндэсний аюулгүй байдлын бодлогодоо Москвагийн аюул заналыг онцолсон учир НАТО-гийн гишүүдтэй энэ чиглэлээр хамтын ажиллагаагаа ойртуулахыг эрмэлзэж байгаа юм. ЕХ-ны 28

Хатагтай Вилбаргер цааш нь "PESCO НАТО-г нөхөх шинж чанартай бөгөөд НАТО-гийн үйл ажиллагаа, шаардлагаас хөндийрүүлээгүй тохиолдолд Вашингтон дэмжих болно. Хэрэв цэргийн түргэн ажиллах чадамжийг зөв хэрэгжүүлбэл Европ ба НАТО-д аль алинд нь тустай. Гэвч бүрэн мэдээлэл алга. Дэд бүтцийн хийгээд хууль эрхийн өөрчлөлт НАТО-гийн шаардлагад суурилаагүй бол бидний зорилго зөрчилдөнө" хэмээн сануулаа. Карнеги Европын захирал, Словакаас НАТО-д суух төлөөлөгч асан Томас Валечек "ЕХ-ны нэгдсэн батлан хамгаалах бодлогын эсрэг хийх АНУ-ын хүчин чармайлт цаг, хугацааны гарз. Галт тэрэг хэдийнэ хөдөлсөн" гэв.

Ноён Мэттис НАТО-гийн уулзалтын өмнө хэлсэн үгэндээ "АНУ-ын зүгээс эвслийг шинэчлэх, ачааллыг тэгш үүрэхийг уриална. Улс бүр ачааны хэсгийг, шударгаар хуваарилан үүрэх шахалтаа үргэлжлүүлнэ"


BBM©

гишүүн орны гурваас бусад нь арванхоёрдугаар сард цэргийн холбоог зузаатгаж, зардлаа нэмэх амлалт авсан билээ. Гэвч PESCO хэмээх Европын батлан хамгаалах 17 зүйлтэй шинэ гэрээнд цэргийн сургуулилалт, цахим хамгаалалт, тив дотор цэргийн харилцан ажиллагаа, дэд бүтцийг сайжруулах арга хэмжээ орсон байна. ЕХ-ны удирдлага Британи, Дани, Мальтаас бусад бүх гишүүн улс гэрээнд баяр хүргээд энэ нь НАТО-той өрсөлдөх бус нөхөх болно хэмээн онцолжээ.

хэмээсэн юм. ДНБ-нийхээ хоёр хувийг батлан хамгаалах зардалд зориулах НАТО-гийн шаардлагыг өнгөрсөн онд тавхан улс биелүүлсэн гэж НАТО-гийн судалгаанд дурдсан байна. Түүнчлэн Трампын засаг захиргаа батлан хамгаалах зардлынхаа наад зах нь 20 хувийг тоног төхөөрөмж худалдан авахад зарцуулах шаардлага тавьсныг гишүүн орнуудын тал хүрэхгүй нь хэрэгжүүлснийг мөн судалгаанд бичжээ.

FT

Оросын засаглалын системийг тайлбарлахад бэрх

Лилия Шевцова

XIX-XX зууны турш Герман улс дэлхийд өөрийн үнэлэмж, үүрэг зорилтоо ойлгохын төлөө тэмцэж, тогтвортой байдлыг бусниулж байв. Гэтэл XXI зууны эхэнд Орос олон улсын толгойн өвчин боллоо. Орос улс өөрийн байр суурийг хайх явцдаа урхинд ороод байна. Хөгжлийн загвар нь өсөлт, тогтвортой байдлыг хангахаа байж, өөрчлөх гэхээр төр улсад нь аюул учрах нөхцөл бүрдлээ. Хувийн эрх мэдэлд суурилсан Оросын систем тайлбарлах аргагүй бодит байдлыг үүсгэв. Энгийн Засгийн газрыг тогтворжуулдаг хүчин зүйлс эсрэгээрээ ганхуулж, хоёрдмол, уялдаагүй байдал нь оршин тогтнох үндэс болж байна. Ирэх сард болох Ерөнхийлөгчийн сонгууль иим парадоксын нэгэн жишээ юм.

Урьдаас тодорхой байгаа үр дүн нь Ерөнхийлөгч Владимир Путины эрх хэмжээг бэхжүүлнэ. Гэвч жинхэнэ өрсөлдөөн байхгүй, Путин төрийн аппаратаас хэт хамаарч байгаа нь түүнийг тойрон хүрээлэгчдийн барьцаанд оруулж, бүхнийг чадагч мэт харагдах үл чадамжаар улсыг удирдахад хүргэнэ. Уг парадоксын өөр нэгэн жишээ нь Кремль засаглалын эсрэг 2011-2012 оны эсэргүүцлийн хөдөлгөөний нухчин дарсан явдал. Элит анги эрх мэдэлтнүүдэд дуугүй хөтлөгдсөн нь амар амгалан мэт байдлыг үүсгэжээ. Төөрч будилан, ёс суртахуун нь доройтсон ард иргэд итгэл хүлээхгүй байсан ч ялгаагүй төрд найдахыг илүүд үздэг. Гэвч энэхүү "шинэ хэвийн байдал" хуурамч байж болзошгүй.

Ард иргэдийн ашиг сонирхлыг илэрхийлэх сувгууд институцжээгүйгээс оросууд дахин гудамжинд гарч, өөрчлөх ганц зам нь хувьсгал хэмээн бодох боллоо. Алексей Навальный иргэний эсэргүүцлийн удирдагч болон гарч ирсэн нь уур хилэнг нүүр царайтай болгов. Гэвч 2014 онд Крымийг авсан явдал үндсэрхэг үзлийг дэвэргэхэд Кремльд тусалсан ч хориг арга хэмжээ авчирсан. Ингэснээр урам зориг нь унтрах тийшээ хандав. Бие даасан Левада төвийн судалгаанд оролцогсдын 55 хувь нь дотоод төсвөөр Крымийг дэмжих нь буруу гэж хариулжээ.

Нөгөө талаас оросууд дэлхийн хэмжээний сөргөлдөөнд бэлэн биш байна. Санал асуулгад оролцогсдын 59 хувь нь "Гадаад

BBM©

бодлого Оросын энх тайван, аюулгүй оршихуйг баталгаажуулах ёстой" гэсэн бол 19 хувь нь өрнөдтэй сөргөлдөхийг дэмжжээ. Түүнчлэн 65 хувь нь Орос улс хуучин Зөвлөлтийн БНУ-удыг хянах шаардлагагүй гэсэн нь Кремлийн их гүрний түрэмгий бодлогыг дэмжихгүй байгаа хэрэг юм. Иймээс Кремлийн гадаад бодлого дотоод байр суурьа бэхжүүлнэ гэж бүрэн нотлох аргагүй. Оросын элитүүд даяарчлалын үр шимийг хүртэж, өрнөдтэй нягт холбогдсон. Гэвч энэ холбоо тэдний өрнөдийн хоригт эмзэг болголоо.

Ноён Путин элитүүдийн сайн сайхныг батлан даахаа зогсоож, эрх баригч ангид цэвэрлэгээ эхлүүлсэн нь тэдний үнэнч байдлыг ганхуулав. Ерөнхийлөгч юу ч ярилаа гэсэн цөөн хүчин зүйл хуучин системийг өөрчлөлтөөс зайлуулж, амьдруулж байна. Нэгдүгээрт, айдас. Путиныг шүүмжлэгчид хүртэл дэглэм нурвал улс задарна хэмээн айдаг. Бүс нутгуудаас бүрддэг улсыг ардчилсан замаар хамт авч явахад хүндрэлтэй байж магадгүй юм. Хоёрдугаарт, либерализм үзэл санааны хувьд Орос нэр хүндээ алджээ. Либерал ардчилсан орнуудын зогсонги байдал, Оросын авлигач системд өрнөдийн оролцоо, системийн гэх либералуудын үл ялиг үүрэг зэрэг нь ганцаар захирах дэглэмд түлхэц өгсөн юм.

Гуравдугаарт, коммунист байсан орнуудын шилжилт нь коммунизмаас зүгээр нэг салахаас хавьгүй нарийн түвэгтэй үйл явц гэдгийг Украйны байдал харуулж байна. Дөрөвдүгээрт, тусгаар тогтнолын асуудал. Оросын тусгаар тогтнолыг хязгаарласан өрнөдийн хууль эрхийн хүрээн дор Орост ардчилал орших боломжтой юу. Үүнийг хүлээн зөвшөөрөх нь сөрөг хүчинд хүртэл амиа хорлосонтой адил хэрэг болно. Москва хоёрдмол байдлыг ашиглан өрнөдтэй "дүр эсгэх" тоглоом тоглож болох юм. Гэвч иим байдал аль хэр удах вэ. Оросууд ганцаар захирах дэглэмийн үүсгэсэн урхаг нь эмх замбараагүй байдлаас айхаас дор гэсэн дүгнэлтэд хүрэх ёстой. Путины дараагийн хугацаа оросуудыг ухааралд хөтөлж магадгүй юм. Эс бөгөөс Орос улс XX зууны турш агуу оньсого хэвээр үлдэнэ.

FT

Эдийн засаг

ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ

Ангиллаа сэргээж чадвал өрсөлдөх чадвар нэмэгдэнэ

Төлбөр тооцооны систем шинэ шатанд гарснаар манай зах зээлд хөрөнгө оруулах боломж нэмэгдэнэ.

Шинэ журмууд удахгүй хэрэгжиж эхэлнэ

Б.Мөнх
ЗГМ

Монголын хөрөнгийн биржийн гүйцэтгэх захирал А.Алтайтай ярилцлаа. Хөрөнгийн зах зээлийн голлох индексийн нэг ТОП-20 өнгөрсөн онд өсөлтөөрөө дэлхийд тэргүүлж, улмаар энэ онд хамгийн анхны давхар бүртгэгдсэн компанийн үнэт цаасыг арилжих нөхцөл бүрдээд байна. Тэрчлэн төлбөр тооцооны T+2 горимыг эргэн нэвтрүүлэх шаардлага уг зах зээлд тулгарч буй.

-Олон улсын индекс тодорхойлогч FTSE Russell компани Frontier зах зээлийн ажиглалтын жагсаалтаас Монголыг хассан. Үүнээс хойш таван сарын хугацаа өнгөрч байна. Хөрөнгийн биржийн зүгээс ямар алхам хийсэн бэ?

-Хөгжиж буй зах зээлийн зэрэглэлд багтах нэн шаардлагатай байгаа. Энэ нь дан ганц Хөрөнгийн биржийн хийх ажил байгаад зогсохгүй Санхүүгийн зохицуулах хороо, Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв зэрэг мэргэжлийн байгууллагын жигд оролцооноос хамаарч байна. Ангиллаа сэргээж чадвал хөрөнгийн зах зээлийн хөрвөх чадвар нэмэгдэнэ. Ингэснээр хөрөнгө оруулагчдад илүү ойртоно гэсэн үг. Төлбөр тооцооны систем шинэ шатанд гарснаар манай зах зээлд хөрөнгө оруулах боломж нэмэгдэх юм.

Арилжааны хэмжээг харахад зах зээлийн даац өссөн

-Хөрөнгийн бирж үүсгэн байгуулагдсанаас хойш 26 жил болохдоо өнгөрсөн жил анх удаа 859.2 тэрбум төгрөгийн арилжаа хийсэн. Энэ нь 2015 онтой харьцуулахад дээд үзүүлэлтээс 57.2 хувиар өссөн байсан. Арилжааны ачаалал нөөц, боломж хэр байна вэ?

-Хөрөнгийн зах зээлд оролцох иргэдийн идэвх өнгөрсөн онд эрчимтэй сэргэсэн жил байлаа. Дотоодын иргэдийн арилжаа зургаан дахин нэмэгдлээ. Зөвхөн дотоодын иргэдийн арилжааны дүн нийт арилжааны 19.5 хувийг бүрдүүлсэн. Арилжааны хэмжээг харахад зах зээлийн даац өссөн байна. Зах зээлд эерэг хүлээлт давамгайлж байна гэж болно. Хөрөнгийн бирж болон Санхүүгийн зохицуулах хорооны зүгээс бүтээгдэхүүнийг түргэн шуурхай гаргах, төрлийг нь нэмэгдүүлэхэд анхаарах хэрэгтэй байна. Хөрөнгийн зах зээл дэх бүтээгдэхүүний нийлүүлэлт нэмэгдэх нь чухал. Иймэрэлт, хэрэгцээ ч иргэдийн оролцоо, хандлагаас ажиглагдаж байна.

-Монголын хөрөнгийн биржийн татварын дараах цэвэр алдагдлын хэмжээ дахин буурсан байна. Үүнд юу ингэж хүчтэй нөлөө үзүүлэв?

-2016 оны сүүлчээр "Миллениум АйТи" системээ биржийнхээ баланс дээр бүртгэсэн. Өмнө нь бирж маань 1.5 тэрбум төгрөгийн үнэлгээтэй компани байсан бол 20 гаруй тэрбум төгрөгийн компани болсон. Уг системийн элэгдэл хорогдлын зардал алдагдлын шалтгаан болсон. 2017 оныг аваад үзэхэд арилжаа урьд өмнө байгаагүйгээр өссөн гэдгийг дурдсан. Үйл ажиллагааны хувьд нэлээд хэмнэлттэй ажилласан. Алдагдал маань 10 дахин буурсан нь маш сайн үзүүлэлт. Арилжааны идэвх өндөр, сайн байсан нь дээрх байдалд нөлөөлсөн.

- **Хөгжиж буй зах зээлийн зэрэглэлд багтах нэн шаардлагатай байгаа.**
- **Арилжааны хэмжээг харахад зах зээлийн даац өссөн. Тэрчлэн зах зээлд эерэг хүлээлт давамгайлж байна.**
- **Хөрөнгийн зах зээл дэх бүтээгдэхүүний нийлүүлэлт нэмэгдэх нь чухал.**

-Монголын хөрөнгийн биржийн журмууд шинэчлэгдэн батлагдлаа. Хэр их өөрчлөгдсөн бэ?

-Арилжааны журмын нэмэлт өөрчлөлт болон Үнэт цаасны бүртгэлийн журам, Үнэт цаасны индекс тооцох журмын шинэчилсэн найруулгыг Санхүүгийн зохицуулах хороо батламжиллаа. Шинэчлэн найруулсан Үнэт цаасны бүртгэлийн журам нь үнэт цаасны давхар бүртгэлийн үйл ажиллагааны зохицуулалтыг сайжруулж, бүртгэлийн ажиллагааг олон улсын нийтлэг практиктай нийцүүлсэн. Харин Үнэт цаасны үнийн индекс тооцох журамд индексийн тооцоолуурыг нарийвчлан зохицуулж, ангиллын индекс тооцох зэрэг томоохон өөрчлөлүүд хийсэн. Мөн Үнэт цаасны арилжааны журамд хаалтын ханшийг илүү бодитой тогтоох зорилгоор сүүлийн нэг цагийн арилжааны жигнэсэн дунджаар хаалтын ханшийг тогтоохоор тусгасан бөгөөд захиалгын шинэ төрлүүдийг идэвхжүүлэх зэрэг нэмэлт өөрчлөлтүүдийг оруулсан.

-Хэзээнээс мөрдөгдөж эхлэх вэ?

-Шинэчлэн найруулсан болон нэмэлт өөрчлөлт оруулсан журмуудыг хэрэгжүүлэх бэлтгэлийг хангаж, энэ сарын 19-ний өдрөөс эхлэн хэрэгжүүлэх гэж байна. "Үнэт цаасны үнийн индекс тооцох журам"-д заасан ТОП-20 индексийн тооцооллын өөрчлөлт болон шинээр тооцох нэг ба хоёрдугаар ангиллын индексүүдийн тооцооллыг оны эхнээс нөхөж тооцохоор болсон.

-Давхар бүртгэлтэй анхны компани удахгүй биржид гарна гэж та мэдэгдсэн?

-Давхар бүртгүүлэх компаниуд эхнээсээ хандаж эхэлсэн. Компаниудад ийм сонирхол их байгаа нь харагдлаа. Эхний компанийн үйл явц үргэлжилж байна. Монголд үйл ажиллагаа явуулж байгаа мөртлөө гадны хөрөнгийн биржид бүртгэлтэй уул уурхайн цөөнгүй компани байдаг. Эдгээр компанийн хувьд давхар бүртгэл нь иргэдээс нийгмийн мандат авах нэгэн боломж юм.

-Хувийн үнэт цаасны бирж үйл ажиллагаа явуулж эхэлсэн. Өрсөлдөөн өрнөх нь ээ?

-Шууд өрсөлдөөн үүссэн гэж хэлж чадахгүй. Урт хугацаанд юу болохыг таашгүй. [ЗГМ]

ЗГМ ТОВЧХОН

» БАНК, САНХҮҮ
Санхүүгийн зохицуулах хорооноос Монголын үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбооны үйл ажиллагааг хангалтгүй гэж дүгнэлээ. Тус холбоо нь өөрийгөө зохицуулах байгууллагын статустай юм.

» УУЛ УУРХАЙ
72.6
Хувь. Аж үйлдвэрийн салбарын нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэлд Уул уурхай, олборлох салбар 72.6 хувийг эзэлж байна.

» ТӨСӨВ
19.2
Тэрбум төгрөг. Энэ онд 8.1 сая баррель буюу 1.1 сая тонн газрын тос олборлож, 223.4 тэрбум төгрөг төсөвт төвлөрүүлэхээр төлөвлөсөн. Энэ оны хоёрдугаар сарын 1-ний байдлаар 616.8 мянган баррель буюу 83.6 мянган тонн тос олборлож, төлөвлөгөө 7.6 хувьтай байна. Мөн улсын төсөвт 19.2 тэрбум төгрөг төвлөрүүлж, 8.6 хувийн гүйцэтгэлтэй байв.

» ИМПОРТ
Улсын хэмжээнд ердийн хэрэглээний 38 хоногийн газрын тосны бүтээгдэхүүний нөөцтэй байна.

» АРИЛЖАА
2.5
Их наяд төгрөг. Монголын хөрөнгийн бирж мягмар гарагийн үнэт цаасны арилжаагаар 25 компанийн 140,736 ширхэг хувьцаа арилжлаа. Үүнээс 12 компанийн хувьцааны ханш өсөж, 13 компанийнх буурав. Энэ өдөр "Тавантолгой" болон "Ариг гал" компанийн хувьцааны ханш хамгийн өндөр өсөлттэй байв.

ВАЛЮТЫН ХАНШ

АНУ доллар	2,400.13
Евро	2,955.64
Япон иен	22.28
ОХУ рубль	41.52
БНХАУ юань	378.17
БНСУ вон	2.22

ДЭЛХИЙД

Дэлхийн худалдааны өсөлтийн төлөв хэвээр байна

Дэлхийн худалдааны салбар энэ оны хоёрдугаар улиралд өсөлтийн бүсэд хэвээр байна гэж Дэлхийн худалдааны байгууллага шинээр танилцуулсан төлөвийн тайландаа онцолсон байна. Худалдааны салбарын үзүүлэлт өнгөрсөн улиралд 102.3 нэгжтэй гарсан нь өмнөх улирлын өсөлтөө хадгалсан дүн болжээ. Үүнд экспортын захиалга болон агаарын ачаа тээвэрлэлт өндөр байсан нь голлон нөлөөлсөн байна. Олон улсын хэмжээнд худалдааны маргаан дэлхийн худалдааны ерөнхий чиг хандлагад шууд нөлөөлөхгүй гэж тус байгууллага үзлээ.

Улс орнуудын худалдааны маргаан тодорхойгүй нөхцөл байдлыг үүсгэх ч эдийн засагт үзүүлэх нөлөө нь худалдаанаас илүүтэй дотоодын нийт бүтээгдэхүүний үзүүлэлтээр илэрхий харагддаг. Дэлхийн худалдааны салбар энэ онд 4.4 хүртэлх хувиар өснө гэж Дэлхийн худалдааны байгууллага тооцоолжээ. Энэ нь 2017 онд гаргасан 3.6 хувийн таамгаас өндөр дүн юм.

ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо:2018 оны 02.14-ны өдөр

ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН НЭР: **Суугчийн талон /boarding pass/ нийлүүлэх тендер**
ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ДУГААР: **МИАТ/201801047**

МИАТ ТӨХК-ийн эрх бүхий тендерт оролцогчдоос **Суугчийн талон /boarding pass/ нийлүүлэх тендер тухай битүүмжилсэн тендер** ирүүлэхийг урьж байна.

Тендерийн баримт бичгийг (хүсвэл нэмэлт хувийг) бичгээр хүсэлтээ гаргаж, эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр иж бүрдэлээр нь **50 000** төгрөг, эсхүл түүнтэй тэнцэх хэмжээний чөлөөтэй хөрвөх валютаар худалдан авч болно. Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн **45** хоногийн дотор хүчинтэй байна.

Тендерт оролцогч нь Санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна.

Үүнд:

Борлуулалтын хэмжээ: 2016, 2017 онуудын нийлбэр нь санал болгож буй тендерийн үнийн дүнгээс багагүй байна.

Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ: Судалсан зээлийн хэмжээ санал болгож буй үнийн дүнгийн 70 хувиас багагүй хэмжээний зээл олгох боломжтой байх;

Аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо: 2015, 2016 он, 2017 оны жилийн эцсийн тайлан

Сүүлийн 2 жил хэрэгжүүлсэн ижил төстэй ажлын жагсаалт: 2016, 2017 он

Аж, ахуй нэгжийн гэрчилгээний хуулбар /нотариатаар баталгаажуулсан/

Татварын газрын тодорхойлолт

Шүүхийн тодорхойлолт

Тендерийн хамт:

1 430 000 төгрөгийн дүнтэй тендерийн баталгаа ирүүлнэ.

Тендерийг **2018 оны 03 дугаар сарын 19-ны өдрийн 10.00 цагаас** өмнө доорх хаягаар ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг **2018-ны 03-р сарын 19-ны өдрийн 10.30 цагт** нээнэ.

Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхтэй.

Дотоодны давуу эрх тооцохгүй

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

**Монгол улс, Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 10-р хороо, Буянт-Ухаа 45,
МИАТ ТӨХК-ийн төв байр, Хангамж, үйлчилгээний хэлтэс
Утас:70049860, Факс:70049919**

ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо :2018 оны 02.14-ны өдөр

ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН НЭР: **Автомат тээшний зүүлт нийлүүлэх тендер**
ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ДУГААР: **МИАТ/201801048**

МИАТ ТӨХК-ийн эрх бүхий тендерт оролцогчдоос **"Автомат тээшний зүүлт" нийлүүлэх тендер тухай битүүмжилсэн тендер** ирүүлэхийг урьж байна.

Тендерийн баримт бичгийг (хүсвэл нэмэлт хувийг) бичгээр хүсэлтээ гаргаж, эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр иж бүрдэлээр нь **50 000** төгрөг, эсхүл түүнтэй тэнцэх хэмжээний чөлөөтэй хөрвөх валютаар худалдан авч болно. Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн **45** хоногийн дотор хүчинтэй байна.

Тендерт оролцогч нь Санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна.

Үүнд:

Борлуулалтын хэмжээ: 2016, 2017 онуудын нийлбэр нь санал болгож буй тендерийн үнийн дүнгээс багагүй байна.

Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ: Судалсан зээлийн хэмжээ санал болгож буй үнийн дүнгийн 70 хувиас багагүй хэмжээний зээл олгох боломжтой байх;

Аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо: 2015, 2016 оны аудитаар баталгаажуулсан тайлан, 2017 оны жилийн эцсийн тайлан

Сүүлийн 2 жил хэрэгжүүлсэн ижил төстэй ажлын жагсаалт: 2016, 2017 он

Аж, ахуй нэгжийн гэрчилгээний хуулбар /нотариатаар баталгаажуулсан/

Татварын газрын тодорхойлолт

Шүүхийн тодорхойлолт

Тендерийн хамт:

750 000 төгрөгийн дүнтэй тендерийн баталгаа ирүүлнэ.

Тендерийг **2018 оны 03 дугаар сарын 19-ны өдрийн 12.00 цагаас** өмнө доорх хаягаар ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг **2018-ны 03-р сарын 19-ны өдрийн 12.30 цагт** нээнэ.

Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхгүй.

Дотоодны давуу эрх тооцохгүй.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

**Монгол улс, Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 10-р хороо, Буянт-Ухаа 45,
МИАТ ТӨХК-ийн төв байр, Хангамж, үйлчилгээний хэлтэс
Утас:70049860, Факс:70049919**

Эдийн засаг

Баялгийн сангийн менежментийг гаднын багаар гүйцэтгүүлнэ

“Эрдэнэс Тавантолгой”-н хувьцааг есдүгээр сарын 30 гэхэд арилжихаар төлөвлөв

З.Цэлмэг
@tselmegZGM

С.Батсайхан/ЗГМ©

Норвегийн баялгийн сангийн зарчмаар ажиллах бол төсвийн сахилга батыг сайжруулах ёстой.

Иргэн бүр эзэмшдэг “Эрдэнэс Тавантолгой”-н 1072 ширхэг хувьцааг эдийн засгийн эргэлтэд оруулах бэлтгэл ажил ид өрнөж байна. Энэ оны гуравдугаар улирал буюу есдүгээр сарын 30 гэхэд Хонконгийн хөрөнгийн бирж дээр гаргахаар төлөвлөн ажиллаж байгааг УУХҮ-ийн сайд Д.Сумъяабазар Америк, Монголын худалдааны танхим (АмЧам)-ын гишүүдэд дуулгалаа.

“АмЧам”-ын энэ сарын уулзалтын зочин болсон Д.Сумъяабазар сайд гадаадын хөрөнгө оруулагч, хувийн хэвшлийнхэнд уул уурхайн салбарт ойрын хугацаанд хэрэгжүүлэх ажил, бодлогын талаар мягмар гарагт нээлттэй танилцуулсан юм.

1072 ХУВЬЦААГ ХОНКОНГИЙН БИРЖ ДЭЭР АРИЛЖИНА

Стратегийн 16 ордыг нэгтгэсэн “Эрдэнэс Монгол” нэгдэл ирээдүйн баялгийн сан болох үүд хаалгыг энэ онд багтаж эхлүүлэхээр шаргуу ажиллаж байгаа аж. “Оюутолгой”-н 66 хувь нь олон улсын хөрөнгийн зах зээл дээр эргэлтэд орсон байхад бид өнөөг хүртэл 34 хувиа бүртгээгүй, “Тавантолгой”-н 1072 хувьцааг excel файлаас гаргаж чадаагүй байгааг тэрбээр шүүмжилсэн. Тиймээс нэн түрүүнд “Эрдэнэс Тавантолгой”-н 1072 хувьцааг эдийн засгийн эргэлтэд оруулж, улмаар “Оюутолгой”-н 34 хувь, “Шивээ-Овоо”, “Багануур” хувьцаат компаниудын тодорхой хувийг дотоодын хөрөнгийн бирж дээр арилжаалахаар төлөвлөжээ. Цаашид давхар бүртгэлийн журмаар олон улсын хөрөнгийн биржид дотоодын компаниудын хувьцааг гаргах замаар хөрөнгийн зах зээлийг уул уурхайн салбартай холбох төлөвлөгөөтэй байгаа юм байна.

Гэхдээ төрийн өмчит компаниудын засаглалыг сайжруулахгүйгээр үүнийг мөрөөдөөд ч нэмэргүй. Тиймээс хөрөнгийн зах зээлд гарах мөсийг зүсэх менежментийн баг нь гадны мэргэжилтнүүд гэдгийг Д.Сумъяабазар онцоллоо. Ингэж байж улс төрөөс ангид, эрүүл засаглалтай хувьцаат компаниуд хөрөнгийн зах зээл дээр тоглогч болох үүд нээгдэнэ. Үүнээс өөр арга ч одоохондоо байхгүй аж.

Баялгийн сан байгуулах таатай тохироо бүрдээд байна

Харин уул уурхайн орлогыг баялгийн сан болгох төлөвлөгөөг УИХ-ын хаврын чуулганаас өмнө Засгийн газарт танилцуулах төлөвлөгөөтэй. Уг ажлыг эхлүүлэхээс өмнө УУХҮ-ийн сайд Казахстаны “Самурак Казынак”, Норвегийн баялгийн сан болон Сингапур зэрэг орны ижил төрлийн үйл ажиллагаа явуулдаг сангуудаас туршлага судалсан аж. Гэхдээ уг санд төвлөрсөн мөнгийг эдийн засагт шууд оруулахгүй. Өмнө нь эдийн засагт шууд оруулснаас төгрөгийн ханш унаж, уул уурхайн орлого хавтгайрсан халамж болж хувирсан гашуун туршлага бий. Тиймээс сангийн менежментийг хэрхэх талаар эцсийн шийдвэр хараахан гараагүй. Тус баялгийн сангийн зарчмаар ажиллах бол төсвийн сахилга батыг сайжруулах ёстой. Норвегийн сан зөвхөн хилийн чанад дахь найдвартай эх үүсвэрт хөрөнгө оруулж, жилийн өсөлтийнхөө 50 хувийг л төсөвт хуваарилдаг зарчимтай аж. Харин Сингапурын “Темасек” сан шиг төмөр зам, дэд бүтэц, цахилгаан станц зэрэг дотоодын хөгжлийн бүтээн байгуулалтыг санхүүжүүлэх зэргээр эрсдэлтэй үйл ажиллагаа явуулах эсэхийг хараахан шийдээгүй байгаа юм байна.

СУУРЬ ХУУЛИУДАД ХУВИЙН ХЭВШЛИЙН ТӨЛӨӨЛЛИЙГ ОРОЛЦУУЛНА

Мөн энэ оноос уул уурхайн ашиглалтын лицензийн худалдаанаас 30 хувийн татвар авахаар болсонд хөрөнгө оруулагчид таагүй байгаагаа уулзалтын үеэр илэрхийлсэн юм. Хариуд нь Д.Сумъяабазар сайд “Бидэнтэй хөгжлийн ижил гараанаас эхэлсэн Казахстан улс тогтвортой бодлого явуулж, уул уурхайн орлогоо зөв захиран зарцуулсны ачаар өнөөдөр дэлхийн 50 том эдийн засагтай орны нэг болсон. Гэтэл бидний нөхцөл байдал үүнээс тэс ондоо. Хамгийн сүүлд л гэхэд төсвийн дагалдах хуулиудад оруулах өөрчлөлтийг хэлэлцэхгүйгээр, УИХ шууд “алхдаад” баталчихсан. Цаашид Ашигт малтмалын тухай зэрэг татвар, уул уурхайтай холбоотой суурь хуулиудын өөрчлөлтөд нухацтай хандана. Ялангуяа, олон улсын байгууллага, томоохон хөрөнгө оруулалт хийж байгаа аж ахуйн нэгжийн төлөөллийг оролцуулан эрх зүйн нэмэлт, өөрчлөлт хийх шударга гэж бодож байна” гэв.

Үүнээс гадна хаврын чуулганд өргөн барихаар бэлтгэж буй Уул уурхайн тухай хуульд “АмЧам”-ын саналыг тусгаж, Ажлын хэсгийн бүрэлдэхүүнээ өргөжүүлнэ гэдгээ тэрбээр мэдэгдлээ.

Энэ он бол уул уурхайн салбарт тун чухал жил болж буй. Түүхий эдийн өсөлтийн мөчлөг эхэлж, олон нийтийн зүгээс ч баялгийн санг дэмжих хандлага бий. Мөн улс төрийн түвшинд ч энэ сэдвээр ойлголцож эхэлсэн. Өөрөөр хэлбэл, баялгийн сан байгуулах тохироо бүрдээд байна. Тиймээс энэ боломжийг алдахгүй ажиллана гэдгээ салбарын сайд “АмЧам”-ын гишүүдэд танилцуулсан. Энэ оныг алдчихвал 2019 онд улс төрийн нөлөөлөл ихэснэ, 2020 онд сонгууль гээд завгүй тул өнөөдөр төлөвлөсөн бүх гол ажил 2021 оноос наашгүй.

Тиймээс ашигт малтмалын өгөөжтэй он жилүүдийг алдахгүйн төлөө хийх ажил их байна. [ЗГМ]

Алтны ханшны өсөлт долоо хоногийн сүүлч хүртэл үргэлжилнэ

Алтны ханш
(ам.доллараар, сүүлийн нэг сард)



Өнгөрсөн баасан гарагаас эхэлж чангарсан алтны ханш мягмар гарагт 1325.8 ам.доллар боллоо.

Харин алттай урвуу хамааралтай ам.долларын ханш өнгөрсөн сарын 30-наас хойш тасралтгүй буурав. Үүнээс гадна голлох валютуудын эсрэг бага зэрэг сулраад байгаа юм.

Гэхдээ алтны ханшны өсөлт энэ долоо хоногийн сүүлчээр саарна гэж шинжээчид үзэж байна. Учир нь АНУ инфляцын мэдээллээ танилцуулж, улмаар Холбооны нөөц бодлогын хүүгээ нэмэгдүүлэх хугацаа наашилж магадгүй байгаа юм.

АНУ-д ажлын байр, цалингийн дундаж хэмжээ нэмэгдэж, үүний зэрэг үр дүн хөдөлмөрийн зах зээлд тусгалаа олно хэмээн шинжээчид таамаглаж байна. [ЗГМ]

ЗАСГИЙН ГАЗРЫН МЭДЭЭ СОНИН
Эдийн засаг, уул уурхайн цогц мэдээллийн ертөнцөд таныг урьж байна
Онлайн захиалга
• Улирал: 5000₮ (62 дугаар)
• Хагас жилд: 10 000₮ (124 дугаар)
• Жилд: 15 000₮ (248 дугаар)
УЛААНБААТАР ХОТЫН БАНК
QR код ашиглахгүйгээр төлбөр хийх бол: 2600079789 тоот дансанд мөнгөө тушаана уу.
tdbpay
tdbpay үйлчилгээгээр цахим сонин худалдан авахдаа
Та доорх QR кодыг уншуулан гүйлгээний утга хэсэгт и-мэйл хаяг, утасны дугаараа бүртгүүлэн
Засгийн газрын мэдээ сониныг өөрийн хүссэн хэлбэрээрээ захиалаарай.
zgm.mn ZGMmn zasagco zgm.mn 70103131 99903581

МОНГОЛД ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛДАГ ГАДААД КОМПАНИУД

НЭР	СИМБОЛ	БИРЖ	ВАЛЮТ	ХАНШ	ӨӨРЧЛӨЛТ %	ОГНОО
RIO TINTO	RIO	ASX	AUD	78.87	▲ +1.12%	2/13/2018
WOLF PETROLEUM	WOF	ASX	AUD	0.016	▼ -11.11%	2/13/2018
PETRO MATAD	MATD	LON	GBX	7.125	▲ +2.52%	2/13/2018
ASPIRE MINING	AKM	ASX	AUD	0.01	▼ -9.09%	2/13/2018
GUILDFORD COAL	GUF	ASX	AUD	0.013	▼ -7.69%	2/13/2018
PROPHECY DEVELOPMENT	PCY	TSX	CAD	3.5	▲ +7.03%	2/13/2018
TURQUOISE HILL RESOURCES	TRQ	TSX	CAD	3.5	▲ +1.45%	2/13/2018
SOUTHGOBI RESOURCES	SGQ	TSX	CAD	0.175	▼ -5.41%	2/13/2018
XANADU MINES	XAM	ASX	AUD	0.56	▲ +3.7%	2/13/2018
ENTREE GOLD	ETG	TSX	CAD	0.235	▲ +2.17%	2/13/2018

ТҮҮХИЙ ЭД

НЭР	СИМБОЛ	НЭГЖ	ХАНШ ($)	ӨӨРЧЛӨЛТ %	ОГНОО
АЛТНЫ СПОТ	XAU	унци	1329.16	▲ +0.49%	2/13/2018
ЦАГААН АЛТ	PLA	унци	977.5	▲ +0.48%	2/13/2018
МӨНГӨ	SIA	унци	16.61	▲ +0.24%	2/13/2018
ЗЭС (COMEX)	HGA	фунт	16.61	▲ +0.24%	2/13/2018
ТӨМРИЙН ХҮДЭР	TIOA	тонн	75.65	▲ +1.01%	2/13/2018
WTI ТОС	CLA	баррель	59.47	▲ +0.3%	2/13/2018
БРЕНТ	COA	баррель	62.84	▲ +0.4%	2/13/2018
БЕНЗИН	XBA		168.15	▲ +0.18%	2/13/2018
БАЙГАЛИЙН ХИЙ	NGA	Mmbtu	2.608	▲ +2.19%	2/13/2018
НҮҮРС (NYMEX)	QZA	тонн	336.55	▲ +0.21%	2/13/2018
НҮҮРС (NEW CASTLE)	XWA	тонн	96.4	▲ +0.68%	2/13/2018
ЭЛСЭН ЧИХЭР	SBA	фунт	13.58	▼ -0.22%	2/13/2018
БУДАА	RRA	центнер	12.38	▼ -0.08%	2/13/2018
БУУДАЙ	WA	бушель	474	▼ -0.42%	2/13/2018
КАКАО	CCA	тонн	2007	▼ -2.57%	2/13/2018
КОФЕ	KCA	фунт	123.5	▼ -0.24%	2/13/2018

Энэхүү ханшийн мэдээлэл нь хүснэгтэд заасан өдрийн 15 цагийн байдлаарх дүн тул үүнээс хойш өөрчлөгдсөн байх боломжтой.

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ

НЭР	СИМБОЛ	ХАНШ (нэгж)	ӨӨРЧЛӨЛТ %	ОГНОО
ЭНЭ ӨДӨР I АНГИЛАЛД				
АПУ ХК	APU	698.77	▲ 0.01%	2/13/2018
ГОВЬ ХК	GOV	23040	▼ -0.17%	2/13/2018
МИК ХОЛДИНГ ХК	MIK	11000	▲ 9.45%	2/13/2018
МАХИМПЕКС ХК	MMX	2800	▲ 0.32%	2/13/2018
МОНГОЛ ШУУДАН ХК	MNP	581.24	▼ -4.2%	2/13/2018
СҮҮ ХК	SUU	249.92	▼ -0.39%	2/13/2018
ТАЛХ ЧИХЭР ХК	TCK	26780	▲ 3%	2/13/2018
ТАВАНТОЛГОЙ ХК	TTL	12110	▲ 11.2%	2/13/2018
АДУУН ЧУЛУУ ХК	ADL	2838	▼ -0.73%	2/13/2018
БАГАНУУР ХК	BAN	2000	▼ -1.23%	2/13/2018
БАЯНТЭЭГ ХК	BTG	12650	▲ 3.01%	2/13/2018
АРИГ ГАЛ ХК	EER	3850	▲ 0.03%	2/13/2018
ГАН ХИЙЦ ХК	GHC	11140	▼ -14.31%	2/13/2018
ХАЙ БИ ОЙЛ ХК	HBO	58	▼ -7.94%	2/13/2018
ХӨХ ГАН ХК	HGN	72.55	▼ -14.65%	2/13/2018

Тухайн өдөр арилжаалагдсан хувьцаа

ДЭЛХИЙН ГОЛЛОХ ИНДЕКСҮҮД

НЭР	СИМБОЛ	ХАНШ (нэгж)	ӨӨРЧЛӨЛТ	ӨӨРЧЛӨЛТ %	ОГНОО
NASDAQ COMPOSITE	CCMP	6981.965	+107.47	▲ +1.56%	2/13/2018
DAX INDEX	DAX	12250.8	-31.97	▼ -0.26%	2/13/2018
TORONTO STOCK EXCHANGE	SPTSX	15241.88	+207.35	▲ +1.38%	2/13/2018
S&P/ASX 200	AS51	5855.9	+35.2	▲ +0.6%	2/13/2018
S&P 500	INX	2656	+36.45	▲ +1.39%	2/13/2018
SHANGHAI COMPOSITE	SHCOMP	3184.959	+30.83	▲ +0.98%	2/13/2018
DOW JONES INDUSTRIAL AVERAGE	INDU	24601.27	+410.37	▲ +1.7%	2/13/2018
TOP 20	MSETOP	21616.25	+298.25	▲ +1.4%	2/13/2018
FTSE 100	UKX	7185.96	+8.9	▲ +0.12%	2/13/2018
HANG SENG	HSI	29839.53	+379.9	▲ +1.29%	2/13/2018
NIKKEI 225	NKY	21244.68	-137.94	▼ -0.65%	2/13/2018